



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын
2019 оны 9 дүгээр сарын 16 өдрийн
ТООТ ТУШААЛЫН ГУРАВДУГААР ХАВСРАЛТ

**БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ЗААВАЛ СУДЛАХ, СОНГОН СУДЛАХ МОНГОЛ ХЭЛ,
ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ, МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,
ФИЗИК, БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ, НИЙГЭМ СУДЛАЛ, АНГЛИ ХЭЛ, ОРОС
ХЭЛНИЙ БОЛОН ЗААВАЛ СУДЛАХ МОНГОЛЫН ТҮҮХ, БИЕИЙН ТАМИР, ДИЗАЙН
ЗУРАГ ЗҮЙ, ТЕХНОЛОГИ, СОНГОН СУДЛАХ ТҮҮХ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН
САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

(Бүрэн дунд боловсрол X-XII анги)

Улаанбаатар
2019



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МОНГОЛ
ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

**Бүрэн дунд боловсрол XII анги
(Заавал болон сонгон судлах хөтөлбөр)**

Улаанбаатар
2019

“Монгол хэл бичиг, уран зохиол”-ын сургалтын цөм хөтөлбөр (2016)

Багийн ахлагч:

Ш.Оюунцэцэг

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга, магистр

Багийн гишүүд

Монгол хэл:

М.Базаррагчаа

Sc.D., профессор, МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Мөнгөнцэцэг

Ph.D., МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Оюунцэцэг

магистр, Боловсролын хүрээлэнгийн ЭША

Ц.Өнөрбаян

Sc.D., профессор, МУБИС, МСТ-ийн эрхлэгч

Ц.Туул

магистр, Шинэ-Эрин сургуулийн багш

Б.Цасанчимэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Ө.Цэндсүрэн

магистр, Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Уран зохиол:

Г.Галбаяр

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн

эрхлэгч

магистр, Нийслэлийн 11 дүгээр сургуулийн монгол хэлний багш

Ц.Март

Г.Нандинбилиг

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

П.Нармандах

Ph.D., МУБИС, УЗ-ын тэнхимийн багш

П.Одсүрэн

Ph.D., Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Д.Туяа

Ph.D., Шинэ-Эхлэл сургуулийн багш

С.Энхбаяр

ScD., профессор, МУБИС, УЗСЗ-н тэнхимийн эрхлэгч

Үндэсний бичиг:

Ү.Ариунболд

Ph.D., дэд профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Д.Баттогтох

Ph.D., Боловсролын хүрээлэнгийн ЭША

Б.Батчимэг

Нийслэлийн 23 дугаар сургуулийн багш

Н.Мөнхцэцэг

Нийслэлийн 39 дүгээр сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Хөндлөнгийн шинжээч:

А.Цог-Очир

Ph.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Ц.Оюун

Sc.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Б.Сүхболд

ЕБ-ын 33 дугаар сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Г.Нандинбилиг

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

Ш.Оюунцэцэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

**МОНГОЛ ХЭЛ
(ЗААВАЛ СУДЛАХ АГУУЛГА)**

Энэхүү баримт бичиг нь монгол хэл бичгийн заавал судлах шинэчилсэн хөтөлбөрийн дагуу арван хоёдугаар ангид хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой удирдамж болно.

12.1. УНШИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>12.1а. Уран нийтлэлийн бүтэц, гол санааг цогцолбор, түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох</p>	<p>Төрөл бүрийн нийтлэл эхээс, уран нийтлэлийг сонгоно.</p> <ul style="list-style-type: none"> - Уран нийтлэлийн бүтцийг түлхүүр үгсээр тоймлон, тайлбарлах - Эхийг цогцолборуудаар задлах - Чөлөөт зураглал, бодит баримт хоёрыг хэрхэн хослуулсныг тайлбарлах - Нийтлэлд ямар мэдээлэл чухалчилж байгааг ялгах, тодруулах - Эхийн сэдэв, гол санааг түлхүүр үгсээр тодорхойлох - Эхийн сэдэв санаанаас үүдэн уран нийтлэл хэрхэн бүтдэгийг дүгнэх - Зохиогчийн сэтгэгдэл, үзэл бодлыг илэрхийлэх үгс эхэд ямар утга илэрхийлж, ямар үүрэг гүйцэтгэж байгааг тодорхойлох - Зохиогчийн ашигласан нэр томъёо, мэргэжлийн үг хэллэгийг хам сэдвийн хүрээнд тайлбарлах - Уншигчийн сэтгэлд нөлөөлөх ямар үг хэллэг ашигласныг ялгаж, тайлбарлах (үгийн сангийн төрөл бүрийн үг хэллэг) - Эхийн агуулгыг төрөл бүрийн аргаар бүлэглэж тайлбарлах - Уран нийтлэл, эсээг харьцуулан ажиглах, эхэд задлан шинжилгээ хийх <p>Багшид зөвлөх нь: Эхийн агуулгын багтаамжийн хувьд, томоохон эх дээр ажиллаж байгаа бол хэд, хэдэн хичээлээр хуваан ажиллах боломжтой ба жишээ нь: эхний хичээл “Удиртгал” хэсэг байх, мэдлэг бүтээх үе шат нь хоёр ба гурав дахь өдрийн хичээл болон “Дүгнэлт” хэсгийг дөрөв дэх өдрийн хичээлээр гүйцэтгэх арга зам юм. Дасгалын явц: Алхам 1: Удиртгал хэсгийн үед ба сурагчдын сонирхлыг төрүүлж, идэвхжүүлэх нэгээс хоёр аргыг хэрэглэх боломжтой ба тухайн сэдвээр сурагчид эхийг ерөнхийлөн баримжаалж ажиглах, ялган тодруулах, сэдвийн гол гогцоо үгсийг танилцуулах зэрэг болно. Энэ нь, утгын зураг болон гогцоо үгээс текстийн утгыг тааварлах дасгал байж болно. Алхам 2: “Чиглүүлэгтэй уншлага” дасгалыг хичээлд хэрэглэж болно. Үүний өмнө багш урьдчилан текстийг гол утга, санааны</p>	<p>Уран нийтлэл: Д.Нацагдорж “Зул” Ж.Лхагва “Буянт ухаа” Б.Ринчен “Цаг ирвээс” “Юуны магад” О.Дашбалбар “Миний нээсэн эх орон” С.Эрдэнэ “Миний эх орон, миний тоонот”</p>

	<p>дагуу хэд хэдэн хэсэгт хуваасан байх ёстой. Хэсэг бүрд гол санааг нь ойлгуулахад дөхөм асуултыг бэлтгэсэн байна.</p> <p>1.Текстийг сурагчид зогсолттой уншина. 2. Асуулт бүхий уншлага (АБУ) арга: Сурагчид текстийг гүйлгэн унших ба багшийн асуултад хариулна. 3. Сурагчид хариултаа баталгаажуулахын тулд текстийн тохирох хэсгийг дахин уншиж баталгаажуулна.</p> <p>Алхам 3: Сурагчид ойлголтоо баталгаажуулж, улмаар шинэ мэдлэг, мэдээллээ хэрэглэх бололцоо олгох дасгалыг багш сурагчдаар ажиллуулж хэвших нь зүйтэй. Ихэнх хичээлд энэ нь гэрийн даалгавар байдаг.</p> <p>Унших ба мэдээлэл ашиглах чадварын хувьд, ном, сонин, сэтгүүл гэх мэт олон төрлийн материалыг уншиж, бичих гэж буй зүйлдээ ашиглах, төрөл бүрийн мэдээлэл цуглуулах, эрэмбэлэх чадвар үүнд хамаарна. Анхан шатанд сурагч хэрэгтэй мэдээллээ ном эх сурвалжаас олж авах аргачлалыг эзэмшсэн бөгөөд цаашлаад олон төрлийн аргаар зөв зохистой мэдээллийг олж, эрэмбэлэх чадварыг төлөвшүүлэхэд анхаарна. Төрөл бүрийн мэдээллийн эх сурвалжийг ашиглан их хэмжээний уншлага хийж, өөртөө хэрэгтэй мэдээллийг олж авах, цаашлаад мэдээлэлдээ үндэслэн өөрийн үзэл бодлоо нэгтгэх зааварчилгаа өгнө. Харин эцэст нь эдгээрийг нэгтгэн зорилгодоо нийцүүлэн ном зохиол, төрөл бүрийн мэдээлэл уншин мэдлэгээ өргөжүүлж, үзэл бодлоо нэгтгэхэд дэмжлэг өгөх хэрэгтэй. Уншина гэдэг нь хүн бие даан ганцаараа хийдэг үйл ажиллагаа бөгөөд өөрийн хүслээр, аяндаа хийдэг болоход л ач холбогдол оршино.</p>	
<p>12.16. Ятгасан эсээний бүтэц, гол санааг цогцолбор, түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох</p>	<p>Ятгасан эсээний хувьд асуудал дэвшүүлсэн, өгүүлэгчийн өвөрмөц санаа бүхий ятган итгүүлэх арга хэрэглүүрийг ашигласныг чухалчилна.</p> <ul style="list-style-type: none"> - Эхээс суурь мэдээлэл буюу үндэслэл, дэвшүүлсэн асуудлыг ялган тодорхойлох - Уншигчийг ятган итгүүлэх арга хэрэглүүрийг анхаарах - Эх нь бичлэгийн ямар төрлөөр бичигдсэнийг ажиглах, тайлбарлах - Баримт нотолгоо, судалгаа, хөндлөнгийн дүгнэлт бодитой байгаа эсэхийг тодруулах - Эхийг зохиогчийн зорилго, эхийн зориулалтыг тодорхойлох, эхийн агуулгыг уншигчийн үүднээс үзэж тайлбарлах - Эхийн найруулгыг өгүүлбэр, үг, бүтээвэр зэрэг хэлний нэгжүүдийг задлан шинжлэх замаар тайлбарлах - Ятган итгүүлэх арга хэрэглүүрүүдийг тус бүрд нь авч үзэж тайлбарлах - Уншигчийн сэтгэл хөдөлгөх арга хэрэглүүдийг тэмдэг нэр, баймж үг, дүрслэл бүхий үг хэллэгээр дамжуулан тайлбарлах, ялган таних - Ятгах хэрэглүүрийг ятгасан үг хэллэгээс үүдэн тайлбарлах - Статистик судалгаа, шинжээчийн дүгнэлт гэх мэт нотолгоо нь эхийн аль өгүүлбэрийг дэмжиж байгааг тодорхойлох 	<p>Л.Түдэв “Аргалын утаа” Л.Түдэв “Сүү мэт сүүл” Ж.Арилдзэмбэ “Талхигдлаас үүсэж буй цөлжилтөөс гагцхүү үлийн цагаан оготны хэт олшролт л аварна” Ж.Гангаа “Хялганат талын цагаан зээр хар цээр биш ээ” Л.Түдэв “Дээшээ доошоо хоёр”</p>

	<ul style="list-style-type: none"> - Өгүүлэгч байр сууриа илэрхийлэн уншигчид итгэл үнэмшил хэрхэн төрүүлж буйг үг, өгүүлбэрийн жишээгээр нотлох, тайлбарлах - Эхийн хэсгүүдэд буй үндэслэл, учир шалтгаан, дүгнэлтийн уялдаа холбоог жишээ баримтаар задлан тайлбарлах - Өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аясыг илэрхийлэх үг хэллэг, хэлц, уран дүрслэл гэх мэтийг ажиглаж ятган итгүүлэх сэтгэл хөдлөлийн арга хэрэглүүрийг тодорхойлох - Зохиогчийн ёс зүйн арга хэрэглүүрийг эхийн жишээгээр тайлбарлах <p>Багшид зөвлөх нь: Эсээний задлан шинжилгээ нь асуудлыг баримтад тулгуурлан олон талаас нь шинжлэн судлах, ажиглан эргэцүүлэх, задлан тайлбарлах, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших, томъёолон таамаглах, адилтган зүйрлэх зэрэг оюуны төрөл бүрийн бүтээлч үйлд тулгуурлана гэдгийг анхаарна.</p>	<p>Г.Лхам “Захидал бичдэг өдрүүдийг эргэн санахуй” Л.Түдэв “Бичгийн ээж нь тоо гэвэл, үсгийн эцэг нь зангилаа”</p>
<p>12.1в. Ятгасан эсээний агуулгыг зохиогчийн үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмж, үнэлэлт дүгнэлт, баримтаар задлах</p>	<ul style="list-style-type: none"> - Эсээний эхлэл хэсэгт буй зохиогчийн үзэл бодол бүхий өгүүлбэрийг тодорхойлох - Эхэд баримт ашигласан зорилгыг тодорхойлох - Судлаачдын бүтээлээс эш татсан зорилгыг тайлбарлах - Баримт ашигласан учрыг тайлбарлах - Баримт нь зохиогчийн үзэл бодлыг батлах үүрэгтэй байгааг тайлбарлах - Уншигчид итгүүлэхийг зорьсон үзэл бодлыг тодорхойлох - Эхийн дүгнэлт хэсэгт буй зохиогчийн хандлагыг тайлбарлах - Санаагаа илэрхийлэхийн тулд ашигласан уран дүрслэл бүхий үг хэллэгийг ялгах, утга үүргийг тодорхойлох - Эхийн уран дүрслэлээр дамжуулан ямар санааг илэрхийлснийг тодорхойлох - Уран хурц дүрслэлд уншигчийг итгүүлэх ямар арга байгааг тайлбарлах - Эхийн агуулгаас үүдэн дүгнэлт, тайлбар бичих - Ятган итгүүлэх арга хэрэглүүр бүхий уншигчийн анхаарал татах үг хэллэгийг ялгах, жагсааж бичих - Үг сонголтын шалтгааныг тайлбарлахын тулд оновчтой жишээ сонгох - Хэлэлцүүлэг тайлбар хийх 	<p>Л.Түдэв “Аргалын утаа” Л.Түдэв “Сүү мэт сүүл” Ж.Арилдзэмбэ “Талхигдлаас үүсэж буй цөлжилтөөс гагцхүү үлийн цагаан оготны хэт олшролт л аварна” Ж.Гангаа</p>
<p>12.1г. Ятгасан эсээний үгийн сан, бүтэц, зохиомж, жишээ баримт, уншигчид нөлөөлөх дүрслэл, зохиогчийн ёс зүйн хандлагыг жишээ баримтаар тайлбарлах, дүгнэх</p>	<p>Эхийн үгийн сангийн хувьд: Зохиогчийн уран санаа бүхий үг хэллэг дээр голлож ажиллана.</p> <ul style="list-style-type: none"> - Тэмдэг нэр, баймж үг, хэлц, уран дүрслэлийг ятган итгүүлэх арга хэрэглүүр болох талаас тайлбарлах - Эхийн өнгө аяс, баймж утгыг судлах (асуух, хүүрнэх, захирах, таамаглах, анхааруулах, эргэлзэх, дурсан санах, батлах, үгүйсгэх гэх мэт) - Зохиогч үзэл бодол, хандлагаа илэрхийлэхдээ ашигласан хэлц нэгжүүдийг ялган түүвэрлэх, тэдгээр нь үзэл бодол, зохиогчийн хандлага ба эхийн гол санааг илэрхийлэхэд ямар үүрэгтэй байгааг ойлгож унших 	<p>“Хялганат талын цагаан зээр хар цээр биш ээ” Л.Түдэв “Дээшээ доошоо хоёр” Г.Лхам “Захидал бичдэг өдрүүдийг эргэн санахуй” Л.Түдэв “Бичгийн ээж нь тоо гэвэл, үсгийн эцэг нь зангилаа”</p>

	<ul style="list-style-type: none"> - Хэлц нэгжүүд нь эхэд төрөл бүрийн баймж утга илэрхийлдгийг тодруулах - Эхийг бүтээж буй өгүүлбэрийн доторх үйл үгсийн утга, үүргээр өгүүлэгчийн үзэл бодол, өгүүлбэрийн баймж утга илэрдгийг таних тайлбарлах - Зохиогчийн хэлэх гэж байгаа санааг ойлгох, тодорхойлох, үзэл бодол, хандлага эхийн аль хэсэгт хэрхэн илэрч байгаад дүгнэлт хийх, бүтээлч тэмдэглэл хийх (зураглал, схем, график г.м төрөл бүрийн аргаар) - Зохиогчийн хэрэглэсэн үг хэллэгийн сонголт, зохиолын үгийн санг судлах - Зохиол дахь хэлний зүй, цэг тэмдгийн хэрэглээг судлах - Эхэд ямар өгүүлбэр, ямар үгсийн аймгийн үгс, ямар дүрслэх хэрэглүүр ашигласан байгааг ажиглуулах, дүгнэлт хийлгэх \УНӨ, оруулсан НӨ, тэмдэг нэр, дүрслэх хэрэглүүр, адилтгасан өгүүлбэр, цэг тэмдгийн хэрэглээ, найруулгын хэм хэмжээ г.м 	
--	--	--

12.2. БИЧИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	хэрэглэгдэхүүн
<p>12.2а. Асуудал дэвшүүлж, баримт нотолгоо, уншигчид нөлөөлөх дүрслэл, эшлэл зүүлт ашиглан байр сууриа илэрхийлж, ятган итгүүлж бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Ятган итгүүлэх, сэнхрүүлэх санаа сэдвээ хайж олох - Ятган итгүүлэх бэлтгэл хийх, итгүүлэх зүйлийнхээ талаар судалж, төлөвлөх - Харилцан ярилцах, хэлэлцэх <ul style="list-style-type: none"> ▪ Уншигчаа тодорхойлох (Бичвэрийг хэн унших вэ? Хэдэн настай хүмүүст зориулсан бэ? Ангийнхандаа юу? Багшдаа юу? Мэргэжлийн хүмүүст үү? гэх мэт асуултыг өөртөө тавьж эсээ бичвэрт хэрэглэх үгийн сонголт, зохиомжоо шийднэ.), ▪ Бичих зорилго (ямар асуудал дэвшүүлмээр байна, уншигчдад юуг хэлмээр байна.) - оо тодорхойлох ▪ Өөрийн гэсэн бусдаас ялгарах өвөрмөц санааг гаргахын тулд сэдвийн хүрээнд аль болох олон асуудал дэвшүүлэх, хэрэгтэйгээ сонгохын тулд тэдгээрийг эрэмбэлэх, жагсаах, ялгах түүвэрлэх, аль нэгийг сонгох, дэвшүүлсэн санаагаа боловсруулах, ▪ Хэдэн хэсэгтэй байх, хэсэг тус бүрд ямар санаа илэрхийлэхийг өөртөө ойлгомжтойгоор төлөвлөх ▪ Эсээний хөтөч санааг гаргаж бичих, түүнийг бусдаас өөр, содон сонин болж чадсан уу? Шийдэж болох асуудал байж чадсан уу? гэдгийг эргэцүүлэн бодох ▪ Өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ уншигчид нөлөөлж чадах утга шилжүүлсэн дүрслэл, зүйр цэцэн үг, хэлц үг гэх мэтийг олж, ашиглах. 	<ul style="list-style-type: none"> - Ц.Өнөрбаян, Ж.Батбаатар нар “Эсээ бичихүйн үндэс” УБ., 2006 - Б. Пүрэв-Очир, “Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ” УБ., 2009 - А.Цог – Очир, Д.Эрдэнэсан нар “Монгол хэлний эхийн хэв маяг”, УБ., 2015

	<ul style="list-style-type: none"> ▪ Асуудлаа дэвшүүлж, уншигчийг итгүүлэхээр зорьж тодорхой шийдэлд хүрэхийн тулд сэдвийн хүрээнд судлах, баримт цуглуулах, цуглуулсан баримтаас хэрэгцээтэй хамгийн чухлыг ялгах, зарим мэдээллийг эсээндээ тохируулан найруулах ▪ Цуглуулсан баримт мэдээллээ, өөрийн үзэл бодолтойгоо хослуулан сэдэвтээ тохируулан эхийн тохирох хэсгүүдэд байрлуулах, дүгнэлт гаргах ▪ Ноороглох, засварлах, эцэслэн бичих, амжилтын шалгууртай дүйцүүлж өөрийгөө шалгах <p>Багшид зөвлөх нь: Сурагчид санал бодлоо уралдуулах, хэлэлцэх, мэтгэлцэх аргад суралцах явцдаа ятгасан эсээ бичих аргаа эрж хайж олох нь чухал юм. Үүний тулд багш сургалтын төрөл бүрийн бүтээлч аргыг сургалтандаа ашиглах нь зүйтэй. Тухайлбал: Дэвшүүлсэн асуудлаар сурагчдын санаа бодлыг өрнүүлэхэд, үнэт зүйлийн тэнхлэг аргыг ашигладаг. Тухайн асуудлаар олон янзын байр суурь байх нь зүйтэй бөгөөд хичээлийн сэдэвтэй уялдаа холбоотой байх хэрэгтэйг багш анхаарна. Аливаа асуудлаар хүн хүн өөр, өөр байр суурьтай байх нь энгийн үзэгдэл гэдгийг багш сурагчдад ойлгуулах ёстой бөгөөд санал бодлоо илэрхийлж, өөрийн үзэл бодлыг хамгаалах боломжийг тэдэнд олгох хэрэгтэй юм. Энэ аргын гол мөн чанар нь сурагчид чухал асуудлыг анхаарч үүний талаар бодож, тунгаасны үндсэн дээр байр сууриа тоймлож илэрхийлэх, үзэл бодлоо тайлбарлаж ойлгуулах, бусдын үзэл бодлыг сонсоход чиглэнэ. Энэ аргыг хэрэглэхэд ойролцоогоор 15 минут орчим зарцуулж болно. Үйл ажиллагааны дараалал нь:</p> <ul style="list-style-type: none"> - Багш анги нийтэд асуудал дэвшүүлэх. Тэр нь “Тийм” “Үгүй” гэж хариулах боломжтой байна. Жишээ нь: “Байгаль орчныг хамгаалах нь чухал.” “Иргэдийн өнөөдрийн хэрэгцээг хангах нь чухал.” гэх мэт - Эхлээд сурагч бүр асуудлыг өөр өөртөө эргэцүүлэн бодож, хариултаа томъёолно. - Өөр байр суурьтай 2 сурагч ангийн 2 хананд очно. Бусад дэмжиж байгаа сурагчид 2 сурагчийг дагалдан, өөр өөрийн тал дээр очно. - Хоёр бүлэг дотроо өөрсдийн байр суурийг тодорхойлж, хэлэлцэнэ. Өөрсдийн байр суурийг хамгаалах үндэслэл дэвшүүлэн, танилцуулахад бэлтгэнэ. - Багш бүлэг, бүлгээс нэг нэг сурагчийг байр сууриа танилцуулахыг хүснэ. Үүний дараа өөрийн бодлоо өөрчилсөн сурагч бүлэг сольж болно. - Ийм байдлаар сурагчид бичих асуудлаа дэвшүүлж, сэдвээ тодорхойлох явцдаа үзэл бодлоо илэрхийлж, бусадтай саналаа солилцоход суралцахаас гадна байр сууриа хамгаалж бүлэгт хуваагдах нь ач холбогдолтой. 	<ul style="list-style-type: none"> - Сурах бичгээс гадна Л. Түдэв, Д. Батбаяр, П.Батхуяг, Д.Баттогтох зэрэг монголын зохиолчдын шилдэг сайхан найруулгатай эсээнүүдээс сонгон ашиглах
--	--	--

<p>12.26. Уншигч, зорилго, нөхцөл байдалдаа тохирсон бүтэц, хэв маягийг сонгон бичих</p>	<p>Уншигч, зорилго, нөхцөл байдалдаа тохирсон бүтэц, хэв маягийг сонгон бичихийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Эхийг унших, уул эхийн шинжийг тодорхойлох - Утга, бүтцийг дуурайлган бичих - Цаг үеийн тулгамдсан асуудлын талаар ярилцах, жагсаалт гаргах - Тодорхой сэдэв сонгох, сэдвийн хүрээнд баримт цуглуулах - Төрөл бүрийн эх сурвалжаас эрэл хайлт хийх - Ямар зорилгоор, ямар асуудал дэвшүүлж, хэнд хандаж бичихээ шийдэх - Уншигчаа тодорхойлохын тулд багаар хамтран ажиллах - Дараах асуултад баг бүр хариулж, жагсаалт гаргах (Баг бүрт самбарын том цаас, паламастр юм уу, маркер үзэг өгнө.) • Чиний сэдэв болон дэвшүүлж байгаа санаа нэг хүнд хүрэх юм уу? Олон хүнд хүрэх юм уу? Эсвэл энэ асуудлыг чинь маш ихээр сонирхдог хүмүүст хүрэх юм уу? • Чиний бичсэн эсээг ямар хүн унших вэ? • Чиний сонгосон сэдвийн талаар уншигч юу юуг нь мэдэж байгаа вэ? Юуг нь эсэргүүцэж болох вэ? Юуг хүлээн зөвшөөрч болох вэ? (Таамаглал маягаар) Үүний дараа, эсээгээ бичих үед энэ жагсаалтыг харгалзах нь юунд хэрэгтэй тухай ярилцана. - Баримт мэдээллийг цэгцлэх, эрэмбэлэх - Эхийг төлөвлөх - Эхлэх аргаа сонгох - Сонгосон сэдвээ бичих алхмын дагуу өрнүүлж бичих - Дүрслэл ашиглаж бичих - Эхийг төгсгөх, дүгнэх - Бичсэн эхийг хянах, сайжруулах <p>Багшид зөвлөх нь: Нийтлэл болон эсээ бичихэд ямар үг хэрэглэх, ямар баримт ашиглах, ямар өнгө аястай бичих нь уншигч нь хэн бэ? гэдгээс шалтгаалан өөр өөр байдаг. Багш энэ талаар сурагчдад лавшруулан тайлбарлана. Үүний тулд “Бодол санааны өрнөлт” аргыг хэрэглэж болно. Энэ нь тухайн сэдвээр аль болох олон санааг дэвшүүлэх арга юм. Үндэслэл: Дэвшүүлсэн асуудлаар аль болох олон, хоорондоо ялгаатай санал, бодлыг нийт сурагчдыг тэгш оролцуулан дэвшүүлэх ба дэвшүүлж буй санаануудыг огт шүүмжлэхгүй байхад анхаарна. “Бодол санааны өрнөлт” арга нь сурагчдын “оюун санааг нээх”-эд</p>	<ul style="list-style-type: none"> - Л.Түдэв “Усан тоглоом” - Д.Маам “Монголын нууц товчоон мину зэ” - Л.Түдэв “Хамар” - Д.Батбаяр “Зардас”
---	---	---

	<p>тусалдаг ба энгийн үед тэр бүр санаанд орохгүй зүйлийг ч энэ аргаар илрүүлэх нь бий. Санаа бүр чухал, зөв байх албагүй ч нэг санаанаас өөр шинэ санаа урган гарч болдог гэдгийг мартаж болохгүй юм. Бодол санааны өрнөлт дасгалыг хичээлээр олонтоо хэрэглэх нь сурагчдын сэтгэлгээг задалж өгөх ач холбогдолтой.</p> <p>Бүлгийн зохион байгуулалт: Бодол санааны өрнөлт дасгалыг анги нийтээр, баг хэсгээр, хосоор, сурагчид бие даан гэх мэт олон хэлбэрээр хийх боломжтой.</p> <p>Хэрэглэгдэхүүн: Бодол санааны өрнөлт явуулахад самбар, шохой, эсвэл үзэг, цаас байхад хангалттай.</p> <p>Хугацаа: 10 минут буюу түүнээс бага хугацаанд явуулна. Дасгалын явц: Алхам 1: Бодол санааны өрнөлт хийх аргыг сурагчдад тайлбарлана. Алхам 2: Багш асуудал буюу сэдвийг маш тодорхой танилцуулна. Алхам 3: Асуудлыг шийдвэрлэх талаар бодох хугацааг сурагчдад өгнө. Алхам 4: Санаагаа хуваалцахыг сурагчдаас хүснэ. Бие биеийн дэвшүүлсэн санааг шүүмжлэхгүй гэдгийг сурагчдад сануулахын зэрэгцээ бусдын санаанд тулгуурлан санаа дэвшүүлэх боломжтой гэдгийг хэлээрэй. Жагсаан бичсэн санаануудыг уншиж өгч болно. Энэ үе шатанд санаануудыг дэлгэрүүлж тайлбарлах хэрэггүй. Алхам 5: Сурагчдын дэвшүүлж буй санаануудыг үргэлжлүүлэн самбарт жагсаан бичнэ. Алхам 6: Одоо сурагч бүр тусдаа дахин 1-2 шинэ санаа дэвшүүлж дэвтэртээ тэмдэглэхийг хүснэ. 8.Хамтран бодол санааны өрнөлт хийнэ. Энэ нь “Бодол санааны өрнөлт” аргын нэг хувилбар юм. (De Bono, 1973),</p>	
<p>12.2в. Эхийг хурааж, дэлгэрүүлж найруулан бичих</p>	<p>Эхийг хурааж, дэлгэрүүлж найруулан бичих нь эхийг унших ба бичих чадварын алинтай холбогдоно.</p> <ul style="list-style-type: none"> - Эх зохион бичихдээ, зохиолч судлаачдын үгийг эшлэл болгон ашиглах - Хөндлөнгийн үгийг ашиглаж, эх өгүүлбэрийг хувиргах - Эхийг товчилж, хурааж бичих - Эхийн бүтцийг тоймлон загварчлах - Эхийг өөрийн үзэл бодлоор дэлгэрүүлж бичих - Үг хэллэгийг ойролцоо утгат үг хэллэгээр солин найруулж бичих - Эхийг дуурайж бичих <p>Энгийн өгүүлбэрийг төрөл бүрийн холбох хэрэглүүрээр найруулгын алдаагүй холбох, эх, цогцолбор бүтээх дадлага хийх. Холбох хэрэглүүрийг оновчтой сонгох.</p> <p>Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Энгийн өгүүлбэрийг холбон зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр бүтээх - Энгийн өгүүлбэрийг холбон угсарсан нийлмэл өгүүлбэр бүтээх 	<p>Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Л.Түдэв, Д.Батбаяр, С.Эрдэнэ, Д.Урианхай зэрэг монголын алдартай уран бүтээлчдийн шилдэг сайхан найруулгын эх, өгүүлбэрийг сонгон ажиллах</p>

	<ul style="list-style-type: none"> - Энгийн өгүүлбэрийг холбон холимог нийлмэл өгүүлбэр бүтээх - Нийлмэл өгүүлбэрийн холбоосыг ялгах, утга үүрэг тайлбарлах - Нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэрээр зааглаад, холбоос тус бүрийг тайлбарлах - Энгийн өгүүлбэрийг холбоосоос сонгон холбож, зөв найруулгатай нийлмэл өгүүлбэр зохиох - Өгүүлбэрийн холбоосыг солих, түүнчлэн утга, бүтцэд ямар өөрчлөлт гарч буйг ярилцах - Өгүүлбэрийн санааг эсрэгээр найруулж бичих - Өгүүлбэрт баймж санаа нэмэх. - Өгүүлбэрт дүрслэх маяг нэмэх - Үгсийг зөв дараалалд оруулж нэг нийлмэл өгүүлбэр болгох - Өгүүлбэрийн найруулгыг хичээнгүйлэн уншиж засах. <p>Багшид зөвлөх нь: Үг холбож өгүүлбэр, өгүүлбэр холбож цогцолбор, цогцолбор холбож эх бүтээх чадварыг хоёр үгийг утга, бүтцийн хувьд зөв холбох дадлагаас эхлэх нь зүйтэй. Хэлний их бага нэгж нь дор бүр нь эсвэл олноор зэрэгцэж хэрэг явдлыг тоочих, эсвэл олноор угсарч хэрэг явдлыг өрнүүлэх ба тухайн үйл ба хэрэг явдлыг зэрэгцүүлэн тоочихын зэрэгцээ угсруулан өрнүүлж цогцолборыг бүтээдгийг эх задлан тайлбарлах явцад ойлгоно. Хэлний нэгжүүдийн хувиргал хийхдээ, логикийн алдаа гарахаас сэргийлнэ. Түүнчлэн хувиргал хийх явцад сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд анхаарна. Жишээ нь:” ... Газар дэлхий бууралтана. Гадаа цас орно. Цаанаа л нэг өнгөлөг. Цаанаа л нэг саруулхан. Нарыг хэн ч үл үгүйлнэ. Цас орж байна. Хүн бүхний сэтгэл нэг л өөдрөг. Сэтгэл нэг л баясгалантай. Гэнэт салхи сэвэлзэнэ. Цас бургилна. Удахгүй хүйтэн эхэлнэ.” гэсэн эх дээр ажиллах алхам:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Газар дэлхий бууралтана. Гадаа цас орно” гэсэн хоёр өгүүлбэр цагаар холбогдох уу?, шалтгаанаар уу? аль алинаар уу? гэдгийг холбож бичсэний үндсэн дээр тайлбарлуулах 2. “Цаанаа л нэг өнгөлөг. Цаанаа л нэг саруулхан” хоёр өгүүлбэр угсрах уу, зэрэгцэх үү? Яагаад?. Өнгөлөг, саруулхан байгаа шалтгаан нь юунаас вэ? Тэгвэл өмнөх хоёр өгүүлбэр энэ хоёр өгүүлбэртэй ямар утгаар, хэрхэн холбогдох гэх мэтчилэн цааш дэлгэрүүлэн, “Нарыг үл хүсэх” - ийн шалтгаан юу вэ? Энэ утгыг ямар холбоосоор илэрхийлэх вэ? 3. Сэтгэл нэг л баясгалантай /байхад, байтал/ Гэнэт салхи сэвэлзэнэ. /ж,н,ээд./ Цас бургилна. ... Аль холбоосыг яагаад сонгох нь зөв бэ? гэх мэт сайтар ярилцаж, ухааруулж, дагуулан ажиллаж, төрөл бүрийн өгүүлбэр, цогцолбор бүтээнэ. <p>Хэлний нэгжүүдийн хувиргал, сурагчдын бүтээлч үйлд тулгуурлах учиртай. Тухайлбал:</p>	
--	---	--

	<ul style="list-style-type: none"> - Ном зохиолыг уншаад эсвэл ямар нэг юмс үзэгдлийг хараад өөрт төрсөн мэдрэмж сэтгэгдэлдээ тулгуурлан уншсан болон харсан зүйлд байхгүй үйл явдал, юм үзэгдэл юм уу аль эсвэл дүрслэлийг өөрийн уран сэтгэмжээр ургуулан, төсөөлж бичих - Уран сэтгэмжээр ургуулан бичих сэдэв нь шинэ содон, тэдний сониуч занг хөдөлгөхөөр, анхаарал сонирхлыг нь татаж, ургуулан бодоход хүргэхээр байх. - Чухам юуны тухай өгүүлэх гэж буйг сэдэн мэдүүлсэн, эхийн турш чиглүүлэгч хөтөч нь болсон, нэг л санаанд төвлөрсөн, өөрийн хандлага, өнгө аясыг оновчтой илэрхийлсэн, уншигчийн анхаарлыг татсан, үнэмшилтэй, сонирхолтой хөтөч өгүүлбэрийг бичих - Сэдэвтээ тохирсон дэд сэдвээ сайтар бодож гаргаад, дэд сэдвүүдэд баримт мэдээллээ харгалзуулах байдлаар мэдээллээ бүлэглэнэ. Мөн тухайн сэдвээр бичихэд үнэхээр хэрэгцээ, ач холбогдол бүхий баримт уу? гэдгээ ялгана. - Төсөөлөн бодох. Уран санаагаар ургуулан бичих нь гүн гүнзгий төсөөллөөс эхтэй тул бүх бодол санаагаа төвлөрүүлж, бичих зүйлээ бүхэлд нь төсөөлөн, дүрслэн бодох. (бодох хугацаа гаргаж өгөх) 	
--	--	--

12.3.СОНСОХ- ЯРИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>12.3а. Үзэл бодол, байр сууриа илэрхийлэн илтгэж ярихдаа жишээ баримт, эшлэл ашиглах</p>	<p>Үзэл бодол, байр сууриа илэрхийлэн ярихдаа жишээ баримт, эшлэл ашиглахын тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Жишээ баримтыг аль болох олон зүйлээс авах, хооронд нь жишиж харьцуулах, яагаад гэсэн асуултыг тавьж ярилцах - Зохиогчийн олон янзын үнэлэмжийг харуулсан, баталсан, илэрхийлсэн баримт нотолгоог гаргаж, итгэл, үнэмшилтэй болгох аргад сурах - Судлаач, шүүмжлэгчдийн үнэлэлт, дүгнэлт зэрэг жишээ баримтыг зохиол бүтээл, бусад эх сурвалжаас олж нэгтгэн, ярих бичихдээ бүгдийг бус чухлыг нь сонгон, боловсруулан хэрэглэх. Энэ нь сурагчдын аливаад ул суурьтай хандаж, бодитой дүгнэлт хийж сурахад хэрэгтэй байдаг. - Сурагч ярих үед баримт нь ямар чухал хэрэглэгдэхүүн болохыг ойлгож, мэдээллийг боловсруулан ангилж, өөрийн болгох - Ярихдаа төлөвлөгөө зохиох, төлөвлөгөөндөө жишээ баримтаа хаана оруулахаа шийдэх - Үндсэн санаагаа хөгжүүлж дэлгэрүүлэхийн зэрэгцээгээр шинэ нэр томъёог тайлбарлаж, жишээ баримт тодорхой эш татах - Баримт хэрэглэгдэхүүнээр бүтээлийн сан бүрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Ц.Сүхбаатар “Монгол хэлний найруулга зүй” УБ., 2011 - Д. Батбаяр, “Бүтээхүйн зүй тогтол буюу сайхныг бүтээх нууц” УБ., 2007. - Ц.Сүхбаатар, П.Увш “Илтгэх урлаг” суралцах бичиг УБ., 2004

	<p>Багшид зөвлөх нь: Илтгэл бэлтгэх нь төлөвлөгөөнөөс эхэлнэ гэдгийг анхаарна. Өөрөөр хэлбэл илтгэлийн анхдагч төрх нь төлөвлөгөө юм.Тиймээс</p> <ul style="list-style-type: none"> - Агуулгыг төлөвлөх - Бүтцийг төлөвлөх - Баримт хэрэглэгдэхүүнийг хаана нь, хэрхэн ашиглахаа төлөвлөхөд сургах явдал хамгийн чухал. Сурагчид илтгэлийнхээ төлөвлөгөөг хэрхэн гаргаж байгаа, түүнийгээ засаж сайжруулж төгс төгөлдөр төлөвлөгөө болгоход нь цаг ямагт багшийн дэмжлэг хэрэгтэй. Тухайн дасгал ажиллуулах явцдаа багш өөрөө бүтээлчээр хандаж, нэмэлт даалгаврыг төлөвлөн хийлгэж болно. Өөрийн хувийн туршлага, нэмэлт хэрэглэгдэхүүн, төрөл бүрийн мэдээллээр баяжуулан дэлгэрүүлэх боломжтой. Сурагчдынхаа эрэлт хэрэгцээ, мэдлэг, чадварын түвшинд тохирч нийцсэн үнэлгээний даалгавар ба шалгуурыг боловсруулах нь нээлттэй. 	<ul style="list-style-type: none"> - Жефри А.Ричардс, Грейг С. Рикет “Мэтгэлцээнд суралцах нь” УБ., 2001 -
<p>12.36. Үндэслэлтэй ярих, бусдын үзэл бодлыг анхааралтай сонсож, дүгнэлт хийх</p>	<p>Үндэслэл сайтай ярьж, бусдын үзэл бодлыг анхааралтай сонсож, дүгнэлт хийхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Шинэлэг асуудлыг олж дэвшүүлэн, сэдвийг нарийн тодорхойлох - Төлөвлөгөө гаргаж, зорилгоо зөв тодорхойлох - Холбогдох нөөц хэрэглэгдэхүүнийг хангалттай бэлтгэх - Хэрэгтэй мэдээллээ сонгож, бүлэглэж цэгцлэх - Бусдын санааг өөрийн санаатай харьцуулах, судалгаа, дүгнэлтийг сайтар нягталж хийх - Төлөвлөгөөний дагуу бичсэн, бүтцийн дэс дараалал зөв, ойлгомжтой байгааг хянах - Олон дахин хянаж сайжруулах - Үндэслэл сайтай, зорилгоо хангасан, хэл найруулгын алдаагүй, бусдын өмнө ярихад бэлэн болсныг хянах <p>Багшид зөвлөх нь: Энэхүү чадварыг эзэмшүүлэхэд сургалтад төрөл бүрийн бүтээлч сэтгэлгээний аргуудыг ашиглах нь үр дүнтэй байдаг. Тухайлбал: Асуудал шийдвэрлэн эрэмбэлэх аргыг ашиглаж болно. Сурагчдыг унших явцдаа төвөгтэй нөхцөл байдалд анхаарлаа хандуулж бололцоот шийдвэрийг эрж хайхад чиглүүлнэ. Зорилго: 1. Тэдний эрэл хайлт хийх сонирхлыг нэмэгдүүлэх 2. Төвөгтэй нөхцөл байдал түүний шалтгаан үр дагаврын тухай өмнөх мэдлэгээ сэргээн санах 3. Сурагчдын анхаарлыг асуудлын гол хэсэгт төвлөрүүлэх</p> <p>Багшийн бэлтгэл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шийдвэрлэх асуудлыг олж харахуйц материалыг сонгож авна. 2. Шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлж, түүний талаарх лавлах материалыг бэлтгэнэ. <p>Үйл ажиллагааны заавар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эх материалаа бие даан уншина 2. Хос хосоороо шийдвэрлэх асуудлаа жагсаан бичнэ 3. Шийдвэрлэх асуудлын жагсаалтыг самбарт нэгтгэн гаргана 	<ul style="list-style-type: none"> - Ц.Сүхбаатар, П.Увш “Илтгэх урлаг” суралцах бичиг УБ., 2004 - Жефри А.Ричардс, Грейг С. Рикет “Мэтгэлцээнд суралцах нь” УБ., 2001 - Ц.Сүхбаатар “Монгол хэлний найруулга зүй” УБ., 2011 - Д. Батбаяр, “Бүтээхүйн зүй тогтол буюу сайхныг бүтээх нууц” УБ., 2007

	<p>4. Жижиг бүлгээр шийдвэрлэх нэг асуудлыг сонгон авч бололцоот шийдвэр болон үр дүнг хэлэлцэнэ</p> <p>5. Шийдвэрлэх асуудлын жагсаалтын ард багуудын гаргасан шийдвэрийг бичиж нэгтгэнэ. Ингэснээр сурагчид өөрсдийн шийдвэрээ батлах эсвэл няцаах, шинэ шинэ шийдвэртэй танилцах, асуудлыг шийдвэрлэх олон хувилбарыг олж харах боломжтой юм.</p> <p>6. Гаргасан шийдвэрүүдийг хэлэлцэж, тоон дугаараар эрэмбэлүүлнэ. Жишээ нь: Сэдэв нь “Ядуурал” сэдвээр шийдвэрийг эрэмбэлсэн нь</p> <table border="1" data-bbox="440 554 1159 953"> <tr><td>Ажлын байрыг нэмэгдүүлэх</td><td>1</td></tr> <tr><td>Боловсрол эзэмшүүлэх</td><td>9</td></tr> <tr><td>Мөнгөн ба эд материалын тусламж үзүүлэх</td><td>10</td></tr> <tr><td>Зээл олгох</td><td>3</td></tr> <tr><td>Мэргэжлийн курс, дамжаанд сургах, шинэ мэргэжил эзэмшүүлэх</td><td>7</td></tr> <tr><td>Тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх</td><td>8</td></tr> <tr><td>Албан бус боловсролд хамруулах</td><td>4</td></tr> <tr><td>Хөдөлмөрийн хүмүүжил олгох</td><td>6</td></tr> <tr><td>Албадан хөдөлмөр эрхлүүлэх</td><td>5</td></tr> <tr><td>Цалин хөлсийг нэмэгдүүлэх</td><td>2</td></tr> </table> <p>Багш дараах байдлаар шийдвэрлэх асуудлын жагсаалтыг сурагчдад өгч болно .</p> <ol style="list-style-type: none"> 1. Үгийн язгуурыг хамгийн хялбар олох арга 2. Нөхцөлийг хурдан цээжлэх арга 3. Өгүүлбэрийг гишүүдээр хэрхэн зөв задлах вэ? 4. Сайн зохиогч болохын тулд яах вэ? 5. Амжилттай суралцахын тулд яах вэ? 6. Унших дуртай болох арга бий юү? 7. Цагаа үр бүтээлтэй өнгөрөөхөд хэрхэн суралцах вэ? 8. Өгүүлбэр зохиох хялбар арга 9. Онъсого тааж сурах арга бий юү? 10. Маргаашийг хэрхэн үр бүтээлтэй өнгөрүүлэх вэ? 11. Аав, ээжийгээ хэрхэн баярлуулах вэ? 12. Дэлгэцийн хамаарлаас салах арга г.м - ээр Төгсгөлийн хэлэлцүүлэгт: Булангийн аргыг ашиглана. 	Ажлын байрыг нэмэгдүүлэх	1	Боловсрол эзэмшүүлэх	9	Мөнгөн ба эд материалын тусламж үзүүлэх	10	Зээл олгох	3	Мэргэжлийн курс, дамжаанд сургах, шинэ мэргэжил эзэмшүүлэх	7	Тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх	8	Албан бус боловсролд хамруулах	4	Хөдөлмөрийн хүмүүжил олгох	6	Албадан хөдөлмөр эрхлүүлэх	5	Цалин хөлсийг нэмэгдүүлэх	2	
Ажлын байрыг нэмэгдүүлэх	1																					
Боловсрол эзэмшүүлэх	9																					
Мөнгөн ба эд материалын тусламж үзүүлэх	10																					
Зээл олгох	3																					
Мэргэжлийн курс, дамжаанд сургах, шинэ мэргэжил эзэмшүүлэх	7																					
Тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх	8																					
Албан бус боловсролд хамруулах	4																					
Хөдөлмөрийн хүмүүжил олгох	6																					
Албадан хөдөлмөр эрхлүүлэх	5																					
Цалин хөлсийг нэмэгдүүлэх	2																					

а. ҮГИЙН САН, ХЭЛ ЗҮЙ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	хэрэглэгдэхүүн
<p>12.4а. Нийлмэл өгүүлбэр дэх “гэ”-т</p>	<p>Нийлмэл өгүүлбэр дэх “гэ” – т өгүүлбэрийг таних тайлбарлахын тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Өгүүлбэрийн найруулгыг ажиглах - Өгүүлбэрүүдийн утга, найруулгын холбоосыг задлан шинжлэх 	<p>“Гэ” холбоос бүхий өгүүлбэрийн жишээ</p>

<p>өгүүлбэрийг таних, тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Өгүүлбэрүүд нь утгаараа ойролцоо, эсрэг, төсөөт, зүйлчилсэн санаатай байдгийг давтан ярилцах, бүтцийн төрөл бүрийн хувилбаруудыг жишээ баримтаар тайлбарлах - Өгүүлбэрийн агуулга, хэлбэрийн ижил ба ялгаатай талыг харьцуулан ажиглах - “Гэ” холбох үг нь хэл зүйн ямар утга үүрэгтэй байгааг тодорхойлох - “гэ” “хэмээ” үйл үгийг төрөл бүрийн нөхцөлөөр хувирган хэрэглэх - 	
<p>12.46. Цөм өгүүлбэрийг гишүүд, гишүүн өгүүлбэр, “гэ”-т өгүүлбэр, хэлц үг зэргээр дэлгэрүүлэн найруулж бичих</p>	<p>Цөм өгүүлбэрийг гишүүд, гишүүн өгүүлбэр, “гэ” – т өгүүлбэр, хэлц зэргээр дэлгэрүүлэн найруулж бичихийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Хэлц өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган холбож бичих - Ерийн өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган холбож бичих - Дүрслэг өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган холбож бичих - Өгүүлэгчийн хэлсэн үг буюу хөндлөнгийн үгийг шууд буюу шууд бусаар дамжуулсныг илтгэх - “гэ” “хэмээ” үйл үг нь тусах үйл үгийн утгаар орсныг таних, тайлбарлах <p>Багшид зөвлөх нь: Үгийн сан хэл зүйн дадлага ажил нь эх ба өгүүлбэрийг зохион бичихээс ангид байх учиргүй юм. Ялангуяа заавал судлах хөтөлбөрийн хувьд, сурагчид хэл зүйн ерөнхий ойлголтыг авч тэдгээрийг хэрхэн ашиглах аргад суралцах нь чухал. Тиймээс энэхүү сэдвийн хүрээнд төрөл бүрийн бүтээлч хувиргалын аргыг ашиглаарай.</p>	<p>Б.Ринчен, Ц.Дамдинсүрэнгийн богино өгүүллэгүүдээс хэлцийг ашиглах</p>
<p>12.4в. Хэлц өгүүлбэрийн гол болон үүдэл санааг тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Бодит нэрлэсэн, эсвэл хийсвэрлэн нэрлэсэн өгүүлбэрийг ялгах - Хэлцийн утгыг монголчуудан утга соёлын өвөрмөц онцлогоор тайлбарлах - Ойролцоо хэлцүүд ямар аргаар бүтсэнийг харьцуулан тайлбарлах - Үгсийг тайлбарлах явцдаа гол үгийг олох - Хэлц өгүүлбэрийг шууд утгатай өгүүлбэртэй харьцуулан тайлбарлах - Солин найруулах, хэлц холбоо үг, өгүүлбэрийг өгүүлбэр ба эхэд оруулж бичих - Өөр өөр аймгийн үгс хэлцэд ямар утгатай орсныг тайлбарлах - Хэлцийн уран дүрслэлийг тайлбарлах - Үүдэл ба гол санааг олох, тайлбарлах, таамаг дэвшүүлэх <p>Багшид зөвлөх нь: Монгол хэлний сургалтын эцсийн зорилго бол иргэн хүн бүрийн эзэмшвэл зохих эх хэлний</p>	<ul style="list-style-type: none"> - М.Базаррагчаа “Монгол хэл 8” сурах бичиг, 3 – 55 дугаар тал, УБ., 1999 - Д. Бадамдорж “Монгол хэлний утга судлал” II дэвтэр, УБ., 2001 - Д. Бадамдорж “Монгол хэлний утга судлал” III дэвтэр, УБ., 2001

	<p>найруулах эрдэмд сургах явдал юм. Хэлц нь монголчуудын ахуй амьдрал, соёл сэтгэхүйн туршлагыг хуримтлуулсан хэлний баялаг сан хөмрөг юм. Иймд уул хэлцийг хэрхэн бүрэлдэж хэвшсэн, хэрхэн дүрслэн бүтээсэн гэдэг талаас тайлбарлахаас гадна тэдгээрийг яриа бичигт оновчтой сонгож ашиглахад сургах нь найруулах эрдмийн нэгээхэн чухал хэсэг болно. Багш, хичээлдээ ашиглах төрөл бүрийн хэлц өгүүлбэрийн баялаг сантай байвал зохилтой. Тухайлбал: Зохиолч Б.Ринчений өгүүлбэрийн найруулгын жишээг дурдъя.</p> <ul style="list-style-type: none">• ... үдэш нь Батбаяр, Жамба, Сүрэн эмгэн хоёрт Лодой баяны зүрхийг амаараа үхүүлснийг ярьж тэр бяцхан хотныхон, сэжиг ихтэй аймхай баяныг элгээ хөштөл шоолж, Сүрэн эмгэн, сүжгээс бурхан, сэжгээс чөтгөр гэж хуучны үгэнд байдаг нь аргагүй үнэн үг дэг ээ. Чи ч бас чи дээ. Мөн ч төрхгүй амьтан шив дээ гэжээ.• Энэ юу бол доо! Ус үзэлгүй дэмий гутлаа тайлж, юмны түрүүнд хэрэг ч үгүй за гэж хэлж орхив уу даа.• Танай ноёд чинь хүнийг өнгөөр нь угтаж, тушаал зэргээр нь үддэгийг одоо л үзэж мэдлээ. Энэ ёозоор бол, танайхны түшмэд шинжлэх ухааны ёстой эрдэмтэн хүнийг ер мөддөө, хүн гэж үзэх шинжгүй дэг ээ.• Одоо энэ шагнуулсан ноёд түшмэд бүгд шинэ отго жинсээ мялааж, хутга тавилгүй мах идэж, хундага тавилгүй архи ууж наргих юм биз дээ. (Б.Р)• Ноёд хутагт нарын өмнө боохойн өмнө хэрээ, борооны өмнө салхи, богдын өмнө элч гэгчээр ширүүн элч давхицгаав. (Б.Р)	
--	--	--

2.10. XII АНГИ

СОНГОН СУРАЛЦАХ АРВАН ХОЁДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

Энэхүү баримт бичиг нь монгол хэл бичгийн шинэчилсэн хөтөлбөрийн дагуу арван хоёдугаар ангид хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд нь багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой удирдамж болно.

12.1. УНШИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>12.1а. Төрөл бүрийн найруулгын эхэд өгүүлбэр, үг, бүтээврийн задлан ялгал хийж, хэлний хувирал, зүй тогтлыг жишээ баримтаар тайлбарлах</p>	<p>Хүүрнэсэн, тоочиж тодорхойлсон, зураглаж дүрсэлсэн, шүүн дүгнэсэн, тайлбарлан таниулсан, хөрөглөж дүрсэлсэн, эргэцүүлсэн, ятган итгүүлсэн гэх мэт хэв маягийн эхүүд нь найруулгын төрлөөр ялгарахыг төрөл бүрийн найруулгын эх хэмээн үзэж болно. Эдгээр хэв маяг нь нэг талаар тухайн эхэд дагнах боловч ихэнхдээ өөр хоорондоо харилцан нэвчиж хосолдог.</p> <p style="text-align: right;">“Монгол хэл багшийн ном 12дугаар анги” Уб., 2018он 67дугаар тал</p> <p>Төрөл бүрийн найруулгатай эхийн үг зүйн онцлогийг харьцуулан тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Төрөл бүрийн найруулгатай эхийн үгийн бүтэц дэх бүтээврийн утга, үүргийг тайлбарлах • Төрөл бүрийн найруулгын эхийн хэл зүйн хэрэглээний онцлогийг жишээгээр харьцуулан тайлбарлах <p>Төрөл бүрийн найруулгатай эхийн өгүүлбэр зүйн онцлогийг харьцуулан тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Төрөл бүрийн найруулгатай эхийн өгүүлбэрийн гишүүдийн хэлбэржилт, утга, байрыг тодруулах, эхийн найруулгад гүйцэтгэх үүргийг харьцуулан тайлбарлах • Төрөл бүрийн найруулгатай эхийн өгүүлбэрүүдийн утга, бүтцийг жишээгээр харьцуулан тайлбарлах • Өгүүлбэрүүдийн утгын харьцааг найруулгын утга, үүрэгтэй нь холбон, жишээгээр тайлбарлах • Бүтэц ба бүтэц бус өгүүлбэрийн найруулгын утга, үүргийг жишээгээр тайлбарлах • Төрөл бүрийн найруулгатай эхээс баймж өгүүлбэрийн хэрэглээг харьцуулан, жишээгээр тайлбарлах <p>Төрөл бүрийн найруулгатай эхийн цогцолборын онцлогийг харьцуулан тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Төрөл бүрийн найруулгатай эхийн сэдэв, гол санааг тайлбарлах • Төрөл бүрийн найруулгатай эхийн үг сонголт, үгийн байрлал нь оновчтой болсныг жишээгээр тайлбарлах • Төрөл бүрийн найруулгатай эхийн баймж утга, уран дүрслэл нь эхийн санаа, өнгө аясад хэрхэн нөлөөлж байгааг харьцуулан, жишээгээр тайлбарлах • Төрөл бүрийн найруулгатай эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог тодруулан, загварчилж, харьцуулан тайлбарлах 	<p>М.Базаррагчаа нар Монгол хэл X Уб., 2006 он</p> <p>А.Цог-Очир нар Монгол хэл багшийн ном Уб., 2018</p> <p>Батбаяр. Д “Бүтээхүйн зүй тогтол” УБ., 2007.</p> <p>Баттогтох. Д “Үгийн ширэнгээр бэдрэхүй” УБ., 2008</p> <p>Хүрэлбаатар. Л “Дуун, утгын яруу зохист” УБ., 2005</p>

	<ul style="list-style-type: none"> • Төрөл бүрийн найруулгатай эхийн цогцолборуудын холбох хэрэглүүрийн утга, үүргийг жишээгээр харьцуулан тайлбарлах • Бүтээвэр нь үгэнд, үг нь өгүүлбэрт, өгүүлбэр нь цогцолборт шатлан багтсаныг задлан жишээгээр тайлбарлах • Төрөл бүрийн найруулгатай эхийн агуулга, бүтцийн задлалын дэлгэрэнгүй тайлбар бичих • Төрөл бүрийн найруулгатай эхийн утга, бүтцийн задлалд үндэслэн хэлний хувирал, зүй тогтлыг жишээ баримтаар тайлбарлах • Төрөл бүрийн найруулгатай эхийн цэг цэглэлийн хэрэглээг тайлбарлах <p>Төрөл бүрийн найруулгатай эхийн үгийн сангийн онцлогийг харьцуулан тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Төрөл бүрийн найруулгатай эхийн үгийн сангийн нэгжийн утга, үүргийг жишээгээр харьцуулан тайлбарлах 	
<p>12.16. Авианы найруулгын утга, үүргийг эхийн жишээгээр тодруулан тайлбарлах</p>	<p>Авианы найруулгын утга, үүргийг эхийн жишээгээр тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Эхийг анхааралтай унших • Эхийн авианы найруулгад эгшиг, гийгүүлэгч авианы найруулга чухал үүрэгтэйг жишээгээр тайлбарлах • Уран зохиолд үйл явдал, юм үзэгдлийг нүдэнд үзэгдэж, чихэнд сонсогдтол тод дүрслэхэд авианы найруулга чухал үүрэгтэйг жишээгээр тайлбарлах • Эхийн авианы найруулга нь яруу найрагт шүлгийн эгшиглэн, сонсголонг уран яруу, айзам хөгжимлөг болгодгийг жишээгээр тайлбарлах • Дүрслэх ба дуурайх үгийн авианы найруулгад гүйцэтгэх утга, үүргийг жишээгээр тайлбарлах • Үг, өгүүлбэрийг хэлэх явцад өгүүлэгчийн сэтгэлийн догдлол, дууны өндөр нам, өнгө аялга нь үгийн утгад нөлөөлдгийг жишээгээр тайлбарлах • Хэлний авиа дангаараа утгагүй мэт боловч үг бүтээж, өгүүлбэрт орохдоо өгүүлэгчийн баймж санааг илэрхийлдгийг жишээгээр тайлбарлах • Эхийн утга санаанд авианы найруулга ямар үүрэгтэй байгааг тайлбарлах <p>Багшийн анхааралд: Авианы хэрэглүүр гэдэг нь утгын ба сэтгэлийн хөдөлгөөний өнгө ялгараа, аяс оруулах авианы бололцоог хэлнэ. Авиа найруулах нь тухайн хэл ярианы уран яруу найруулгыг ихэсгэж чадах агуулгатай зохицсон дуудлагатай үгийг сонгон аваад тухайн тохиолдолд оновчтой хэрэглэхийг хэлнэ. Найруулга зүй нь хэл яриаг яруу сонсголонтой, чихэнд чимэгтэй болгохын үр үндэс юу байна вэ? Авиаг хэрхэн ашиглавал уул авиа яруу тунгалаг сонстох вэ? зэрэг асуудлыг судална. Иймд авианы найруулгын утга, үүрэг нь найруулгыг яруу сонсголонтой болгохын хамт хэлэх сонсоход эвгүй, төвөгтэй авиаг сонгохоос зайлсхийж дуудлага яруу болгох уран хэллэгийн нэгэн чанар юм гэсэн талаас задлан тайлбарлана.</p>	<p>Ц.Сүхбаатар Монгол хэлний найруулга зүй УБ.,2015</p> <p>А.Цог-Очир нар Монгол хэл багшийн ном 12 УБ., 2018 он</p> <p>Д.Баттогтох нар Монгол хэл 10 УБ., 2006 он</p>

	<p>Хэлний авиа дангаараа утгагүй мэт боловч үг бүтээж, өгүүлбэрт орохдоо өгүүлэгчийн баймж санааг илэрхийлэх тул хэл найруулгад чухал холбогдолтойг жишээгээр тайлбарлаж ярилцана. Энэ үйл ажиллагааны үр дүнд хүүхдийн хэлний мэдрэмж хөгжихөөс гадна найруулгад үг, өгүүлбэр төдийгүй ганц авиа ч үүрэгтэйг ойлгож, эх хэлээ хүндлэх хандлагад нь нөлөөлнө.</p> <p>Үгэнд төдийгүй авианд хүртэл амин утга буй. Хэлний авиа үг бүтээж оролцохдоо маш нарийн утга илэрхийлж, авианы амь үгэнд төдийгүй өгүүлбэрт, цаашлаад эхэд амь оруулж байдаг. Тухайлбал:</p> <p>“р” авиа хатуу чанга, бүдүүн хатуу, эрчимлэг “л”, “ж” авиа хөнгөн, зөөлөн, сул, аядуу, дөлгөөн, “с”, “ш” авиа шуугиант, исгэрэх дуу чимээлэг “г”, “д”, “т” авиа тэсрэх дэлбэрэх, дуурхаг утгыг зааж амилдаг</p> <p>Богино эгшиг огцом түргэнийг, Урт эгшиг уянгалаг айзамлаг хөгийг бүрдүүлдэг гэх мэт.</p> <p>Б.Явуухулааны “Нүүдэлчний намар” шүлгийн задлалаас. (О.Дашбалбар)</p> <p>Судлаачдын тэмдэглэснээр, энгийн өгүүлбэрүүдийг хооронд нь зэрэгцүүлэн холбодог нөхцөл үйл үгийн нэгдүгээр бүлгийн "урьдчилахын -аад" /зэрэцэхийн -ж, хамын -н/ нөхцөлөөс зориуд "тэсрэх" чанга гийгүүлэгч "д"-г хасаж найруулсан хийгээд шүлгийн сүүл холболтыг эгшгээр уртасгаж зохиогчийн сэтгэлийн догдлол яруу хандлагыг илэрхийлэх баймж бүтээвэр болсон "л"-тэй хамт дуудагдах нь баймжит утгатай, зөөлөн эгшиглэнтэй, айзам хэмнэл, хөг ая зохицсон зохист аялгуун болох үндэс болжээ. Үгээс ганцхан авиаг хасах буюу нэмэх, тэрчлэн дээрх шүлгийн тухайд бол шинэ үг бүтээх бус үг хувилгах үүрэгтэй нэг л нөхцөлөөс ганц авиаг хасаж найруулахад өгүүлбэрийн утга хэл найруулга тухайн санааг илэрхийлэхэд ямар зохистой, яруу нийлэмжтэй болж болдогийг мэдэж болох юм. Шүлэг зохиолын хэл найруулгын задлалд бид багыг бага гэлтгүй нэг авианы. үүрэг хэрэглээ, утга найруулга, өнгө аяс, аялгуу хэмнэлийн тухай ярихдаа өөрөөр хэлбэл авианы найруулгыг анхаарахгүй байж болохгүй бөгөөд нэг авиа хэдэн өгүүлбэрийн утга, бүхэл бүтэн эхийн санааг төгс төгөлдөр илэрхийлэхэд, зохиолын найруулгад ямар чухал үүрэгтэй болохыг дээрх шүлгийн авианы задлалын найруулгаас харж болох байна.</p>	
<p>12.1в. Үгийн сангийн найруулгын үүрэг, онцлогийг тайлбарлах</p>	<p>Үгийн сангийн найруулгын утга, үүргийг жишээгээр тодруулан тайлбарлах Хуучин үг хэллэгийн утга, үүргийг жишээгээр тодруулан тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Эхээс хуучин үг хэллэгийг тодруулах • Эхийн хам сэдвээс хуучин үг хэллэгийн найруулгын утгыг тайлбарлах • Эхийн хам сэдвээс хуучин үг хэллэгийн үүргийг жишээгээр тодруулан тайлбарлах • Хуучин үг хэллэгийн толь бичиг хөтлөх <p>Багшийн анхааралд:</p>	<p>Ц.Сүхбаатар Монгол хэлний найруулга зүй УБ.,2015</p> <p>Д.Отгонсүрэн</p>

	<p>Найруулга зүйн цөм асуудал бол үгийн сангийн найруулга зүй юм. Сүүлийн үед утга зүй, мөн үгийн сангийн найруулга зүйд үгийг тогтолцоот холбоонд нь, олон янзын байдалд нь, тухайлсан хам сэдэвт нь авч үзэхийг шаардаж байна. Найруулга зүй нь үгийн олон утга, ойролцоо утгатай үгс, эсрэг утгатай үгс, төсөөт үгсийн хэрэглээ үүрэг байрыг тодорхойлохын зэрэгцээ утга зохиолын хэлний хэм хэмжээний дагуу зарим үг хэллэгийг хязгаарлах, түүний найруулгын өнгө аясыг илрүүлэх арга ухааныг судалдаг бөгөөд үгийн сангийн найруулга зүйн хувьд үг зөвхөн нэрлэлтийн нэгж бус, өөрийн гэх хэрэглээний үүрэгтэй, үнэлэмжтэй, утга учиртай, хам сэдвийн ач холбогдолтой нэгж төдийгүй мөн уран яруу илэрхийлэх хэрэглүүр юм.</p> <p>Тиймээс багш үгийн сангийн нэгжийн утга, үүргийг хам сэдвээс тусад нь тайлбарлахаас илүү хам сэдэв дунд нь, хэрэглээнд нь сайтар ажиглуулах, найруулгад гүйцэтгэж байгаа үүрэг, өнгө аясыг тайлбарлуулах, хэрэглээ нь зөв, зохистой эсэх, зохисгүй бол хэрхэн өөрчлөх, яагаад зэргээр ярилцах хэрэгтэй.</p> <p>Хуучин үг хэллэг: Хэлний хөгжлийн явцад нэг үг хэллэгийг ойролцоо утгатай өөр идэвхтэй үг хэллэг шахан түрснээс болж улмаар огт хэрэглэгдэхгүй болсон юм уу, маш ховорхон орох болсон үг хэллэгийг хуучин гэж нэрлэдэг.</p> <p>Хуучин үг хэллэгийг хэд хэдэн үүргээр хэрэглэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Өнгөрсөн үеийн түүхт үнэн байдал, үйл явдал, хүний дүр төрхийг бодитойгоор дүрслэн үзүүлнэ. • Уран зохиолын баатрын хэл ярианы онцлогийг гарган, уг баатрын тухай тодорхой төсөөлөл бий болгохын тулд үг ярианд нь тэр үеийн үг хэллэгийг хэрэглэнэ. • Үг ярианд сүрлэг ёсорхуу, ойр зуурын ярианаас эрс ялгаатай, бичиг судрын уур амьсгал оруулах зорилгоор хэрэглэнэ. <p>Хуучин үг хэллэгийн найруулгын утга ярилцана.</p> <p>М.Баярсайханы дараах тайлбарыг уншаад, харь хэлний элдэв үгийг яаран сандран авахын оронд олон зууны бичгийн шастирт байх үгийн уурхайгаа нээж, ганц нэгээр ч болов сэргээн хэрэглэх нь тал талын нь хэрэг тустай бөгөөд ийм үг, жишээ баримтыг багш, сурагчид олноор цуглуулж, мэдэж хэрэглэж хэвших нь бидний хичээлийн бас нэг эрхэм үүрэг болохыг анхаарна.</p> <p>Жишээ нь: Тутарга үзээгүй хүн олон гэж үү? Манайхны олонх нь үгийн баялаг муу, зарим эд өлөг, юм үзэгдлийг заасан монгол үгийг мэдэхгүйдээ тайлбар маягаар санаагаа илэрхийлэх нь улам бүр газар авсаар байна. Ярианы хэлэн дэх тийм тайлбар холбоо үгийг улмаар үгийн сангийн нэгж болгон бичгийн хэлэнд нэвтрүүлснээс чухам монгол үг нь хэрэглээнээс гарч мартагдах боллоо.</p> <p>Зарим нэгэн жишээг дурдъя. Бичиг номоос хөндий, гэрийн ажилтай авгайчуулаас аваад нэг хэсэг нь цаад үгийг нь мэдэхгүйдээ хэдэн зүйл будааг гадна өнгө дүрсээр нь ялган цагаан будаа, шар будаа, гурвалжин будаа хэмээн өөрсдийнхөөрөө хэлж түүнийг нь хүүхэд, ач гуч нар нь мөн тийм л нэртэй юм байна гэж ухаарсаар хэдэн үе болж, барааны нэр шошгоос аваад юм юман дээр өнөөх тайлбарлаж хэлдгийг нь тавих болов. Оюутнуудаас асуухад тутарга гээч юмыг идэж</p>	<p>Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй Уб., 1997 он</p> <p>Ж.Бат-Ирээдүй Монгол хэлний үг, утгын сан Уб., 2006 он</p> <p>Ж.Төмөрцэрэн Монгол хэлний үгийн сангийн судлал Уб., 2001 он</p> <p>Ц.Өлзийхутаг Монгол хэлний үгсийн сангийн судлал Уб., 1979</p>
--	--	---

үзээгүй, хараагүй гэж хариулах нь цөөнгүй байна. Хэрвээ сонин хэвлэлд тутарга (цагаан будаа), хоног амуу (шар будаа), сагаг (гурвалжин будаа) гэсэн нэрээр нь тогтмол бичиж байсан бол олонхоороо ингэж үл мэдэгчин болохгүй байсан биз ээ. Ярианы хэлний үгсийг тэр бүр бичгийн хэлэнд нэвтрүүлээд байдаггүй. Нэг дэх өдөр, хоёр дахь өдөр, хагас сайн (өдөр), бүтэн сайн(өдөр) гэх мэтчилэн тайлбар маягаар хэлдгийг сонин хэвлэлд бичдэггүй шүү дээ.

Эдүгээ чухам үгийг нь үл хэрэглэн тайлбараар голдуу санаагаа илэрхийлж буй жишээг дурдвал, сондор гэхийг хүзүүний зүүлт, барагшин - замын хар, батарга- гахайн хоол, сараана - төмсний улаан, дагалай - эрээн тахь, нар тэмээ - нэг бөхтэй тэмээ, гулд - зам дагуу чигээрээ, аадар - дуу цахилгаантай ширүүн бороо, борог мах - өөхгүй мах, буйдуур - хогийн шүүр, аньсага - нүдний зовхи, бэлэнги - аяны хуурай хүнс, зуд - цаг агаарын түр зуурын бэрхшээл гэх мэт олон үгийн жагсаалт гарах буй.

Шинэ үгийн утга, үүргийг жишээгээр тодруулан тайлбарлах

- Эхээс шинэ үг хэллэгийг тодруулах
- Эхийн хам сэдвээс шинэ үг хэллэгийн найруулгын утгыг тайлбарлах
- Эхийн хам сэдвээс шинэ үг хэллэгийн үүргийг жишээгээр тодруулан тайлбарлах

Нийгмийн хувьсан хөгжихийн дагуу нийгмийн ахуйд шинэ юм үүсэж, хуучин юм алга болж байдаг хуулийг дагаж, нийгмийн үзэгдэл болсон хэлд тэр шинэ юм ойлголтыг тэмдэглэсэн үг бий болж, хуучин юм ойлголтыг тэмдэглэсэн үг үгүй болж байдаг нь хэлний зүй тогтол юм. Аливаа юмс үзэгдэл шинээр буй болсныг тэмдэглэсэн үг хэллэлийг шинэ үг хэллэг гэнэ.

Гадаад үгийн утга, үүргийг жишээгээр тодруулан тайлбарлах

- Эхээс гадаад үгийг тодруулах
- Эхийн хам сэдвээс гадаад үгийн найруулгын утга, үүргийг жишээгээр тодруулан тайлбарлах
- Эхэд орсон гадаад үг оновчтой эсэхийг нягтлах, оновчгүйг нь хэрхэн солин найруулах талаар ярилцах
- Эрдэм шинжилгээний найруулгад гадаад үг нэр томьёо ямар үүрэгтэй байгааг дүгнэж ярилцах
- Гадаад үгийн зохисгүй хэрэглээг жишээгээр тодруулан тайлбарлах
- “Эх хэлний цэвэр ариун байдал ба гадаад үгийн хэрэглээ” – сэдвээр асуудал дэвшүүлэн эсээ бичих

Багшийн анхааралд:

Гадаад үг нь шинжлэх ухааны нэр томьёо, олон улсын эсвэл нийтийн шинжтэй үг хэллэг, утга зохиолын хэлэнд орж идээшин, байргашаад олноор хүлээн зөвшөөрсөн бол, мөн уран зохиолын найруулгад дүр дүрслэлийг тодруулах зорилгоор хэрэглэнэ. Бусад тохиолдолд хязгаарлана. Гадаад үг хэллэгийн хэрэглээний талаар гудамж талбайн хаяг, зар сурталчилгаа, өдөр тутмын хэвлэл нийтлэлээс жишээлэн сайтар ярилцах хэрэгтэй юм.

Монголоороо хэлж бичье. М.Баярсайхан

	<p>Шинжлэх ухаан, техникийн хөгжил, байгаль нийгмийн аливаа хувьсал өөрчлөлтийг дагалдан шинэ шинэ ухагдахуун, тэдгээрийг тэмдэглэх үг хэллэг, нэр томьёо бий болж байдаг нь соёл иргэншлийн жам билээ. Бид эх хэлнийхээ нөөц чадамжийг бололцооны хэрээр уудлан тэдгээр үг хэллэг, нэр томьёонд дүйх монгол үг олж хэвшүүлэхийг хичээлтэй. Энэ нь тун хариуцлагатай, амаргүй хэрэг боловч, сэтгэл гарган хичээгээд байвал харь үг цөөрөх нь дамжиггүй.</p> <p>Гэтэл өнөө цагт тийнхүү эх хэлнийхээ үгийг хэвшүүлэхийг хичээх байтугай, нэгэнтээ тогтсон хэн бүхэн сайн мэдэх монгол үгээ байсаар атал харь үгийг хэрэглэсээр буй нь харамсалтай. Хамгийн олон тохиолддог ийм үгсээс тоочвол: гадил (банана), жигнэмэг (печенье), чанамал (варенье), нөөш (консерв), жимүүс (сок), гахиур (цемент), улаан лооль (томат, помидор), амтат жүрж (мандарин), бэрсүүт жүрж (апельсин), хэм (градус), бадай (комбинезон), туншил (ампул), цац (пирамид), хэвлүүр (принтер), явц (процесс), чадамж (потенциал), халаагуур (пар), шүүгээ (шкаф), нимбэг (лимон), уралдаант шалгалт, элсэлтийн шалгалт (конкурс), товхимол (брошюр), цомог (альбом), төхөөн (чердак), зуслан (зуны лагерь), анкет (байцаалга), төмөрлөг (металл), тавирь (гараж), бүртгэл (регистр), бие хамгаалагч, амь сахигч (бодигаад), агаарын компани (авиа компани), тогтолцоо (система), загвар (мода), дугаар (номер), нэгдсэн эмнэлэг (клиник), үнэмлэх (пропуск), сонсголуур (сонсголын аппарат), хөхөвч (лифчик), иллэг (массаж), сорилго (тест), цочрол (шок), төмөр шүүгээ (сейф), мөрдөс (погоон), өргүүр шат (лифт), чансаа (рейтинг), осол (аваар), цахилгаан зуух (плитка), дуулга (каска), нарны халх (зонтик), тэтгэвэр (пенсия), гоо засал (косметика), хөгжим (мюзик), догол мөр (абзац), зулбуулах (аборт), аварга загас (акула), эмийн сан (аптека), ачаа, тээш (багаж), ян (бактери), нян, хоруус (вирус), гулдан (балка), тагт (балкон), дайллага (банкет), өрмөнцөр (вафли) ...</p> <p>Албан үг хэллэгийн утга, үүргийг жишээгээр тодруулан тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Албан бичгийн эхэд байгаа албаны үгийн утга, үүргийг тодруулан тайлбарлах • Уран зохиолын эхэд дүрийн үг ярианд албархаг үг хэллэгийг ямар үүргээр сонгосныг тайлбарлах • Радио телевизийн нэвтрүүлэг, илтгэл, сурталчилгаа, хүний ярианаас албархаг үг хэллэгийн зохисгүй хэрэглээг жишээгээр тодруулан тайлбарлах 	
<p>12.1г. Үг, бүтээвэр, холбоо үг, нөхцөлөөр найруулгын зэрэг, баймж утга, өнгө аяс илэрхийлэх</p>	<p>Үг, бүтээвэр, холбоо үг, нөхцөлийн баймж утгыг жишээгээр тодруулан тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Эхээс баймж утгатай үг, холбоо үг, бүтээврийг таних, ялгах • Бүтээвэр, үг, өгүүлбэрийн баймж утга найруулгад илрэх өнгө аяс, үнэлэмжийн ялгааг жишээгээр тайлбарлах • Төрөл бүрийн найруулгатай эхийн баймж утга нь эхийн санаа, өнгө аясад хэрхэн нөлөөлж байгааг харьцуулан, жишээгээр тайлбарлах <p>Багшийн анхааралд: Өгүүлэгч тухайн юмны шинж чанарыг тодорхойлох, мөн хэд хэдэн юмыг харьцуулахдаа үзэл бодол, санал сэтгэгдэл, хүсэл</p>	<p>М.Базаррагчаа Монгол хэлний сүегэр ба найруулбарын тухай Уб., 2003 он</p> <p>М.Базаррагчаа</p>

<p>аргыг харьцуулан тодорхойлж, дүгнэх</p>	<p>эрмэлзэл, үнэлэмж хандлагаа илэрхийлдэг. Үүнийг баймж гэнэ. Өөрөөр хэлбэл, өгүүлэгч этгээд бодит байдлын тухай мэдээлэхдээ тухайн зүйлдээ итгэсэн, эргэлзсэн, дурлаж шимтсэн, тушааж захирсан, хүсэж гуйсан, урьдчилан сануулсан, зөвшөөрсөн, шаардсан, хориглосон, ерийн хүүрнэсэн, асууж лавласан зэрэг бодит байдалд хандах харьцаа хандлага янз бүрээр илэрнэ. Үүнийг баймж гэнэ. Баймж нь хэлний бүх түвшинд, хэлний бүх нэгжээр илэрдэг. Баймжгүй өгүүлбэр бол “сүнсгүй” буюу сэтгэлгүй өгүүлбэр болно. Сэтгэлээсээ үгээ хэлэх, үгэндээ сэтгэл шингээж хэлэхэд (бичих) баймж үг, баймж утга тусална. “Сэтгэлийн үг сэтгэлд шингэнэ” гэдэг. Жишээ нь: Ээж-Эх-Ижий гэсэн ижил утгатай гурван үгийг холбоо үгэнд оруулж хэлээд үз. Аль үг (холбоо) нь илүү сэтгэлтэй, уянгалаг (баймж утгатай) үг байна вэ? гэх мэтээр ярилцаж тайлбарлана. Жишээ нь.</p> <p>Б.Явуухулангийн “Нүүдэлчний намар”. "Аяа хөөрхий, нүүдэлчний намар аа гэж" гэсэн найрагчийн сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн яруу хандал нь уран найруулгын нэгэн маяг төдийгүй найрагчаас бодит байдлын яруу сайханд хандан харьцаж байгааг нээсэн баймжит санаа бүхий дүгнэлт болно. "Аяа хөөрхий" гэсэн хандсан үгээр байгаль аж төрлөөс үүсгэлтэй малчны сэтгэлийн хөнгөн гуниг санаашрлыг илтгэсэн бол "аа гэж" гэдэг хамаатахын ба "гэ" язгуурт туслах үйл үгээр "намар" гэсэн бодот нэрийг даган чимж өгүүлэгчийн баймжийн утгыг илтгэжээ. (О.Дашбалбар)</p> <p>“Сиймхий ч бол гэр минь Сэгсгэр ч бол ээж минь” гэсэн хоёрхон шад шүлэгт ямархан гүн нарийн утга, сэтгэлийн энхрий аяс, яруу сайхан хэллэг байна вэ. Сиймхий гэр, сэгсгэр ээж гэдэг нь доромж найруулгын дорд үг, төрж өссөн гэр, төрүүлж өсгөсөн ижийгээ үл ойшоон доршоосон мэт өнгөц сэтгэгдэл төрж болно. Гэтэл дээрх холбоо хоршиц нь “ч, бол, минь” гэсэн баймж бүтээвэртэй нийлэн хэлбэржээд илэрхийлж байгаа утгын өнгө нь эрхэм нандин, сэтгэлийн үг, эвийлж хөөрхийлсөн, энхрийлж хайрласан санаж санагалзсан сэтгэлийн уянга хайланг илтгэжээ. Д.Баттогтох</p> <p>Ж.Бадраа “Сүлд модны наадмын дуун” даа Цалин мөнгөн тэнгэртээ Цасан угалз наадуулсан Цагаан торгон өмсхөлдөөн Цацаг чимэг сагсуулсан хэмээн “ца” язгуурт “цалин, цасан, цагаан, цацаг” зэрэг цагааны өнгө өгсөн авиа үсгийн нийлэмжийг дөрвөн шадын толгойд оруулж, улмаар “цалин мөнгөн”, “цасан угалз”, “цагаан торгон”, “цацаг чимэг” зэрэг хоршоо холбоо үгийн түвшинд мөнөөхөн цагааны өнгөө улам хүчжүүлж “цалин мөнгөн тэнгэр”, “цасан угалз наадуулсан”, “цагаан торгон өмсхөл”, “цацаг чимэг сагсуулсан” гэхлээр бүр тодорхой өвлийн цагаан өнгө нь өвөл болдог цагаан өнгийн цангинасан, цалгисан, цовоо цолгин, гэгээтэй баяртай цагаан өнгөнд давхар шилжиж, цасан цагаан, цангинам чанга өвлийг сүрлэг, дорвилог, өлчир чийрэг эрчтэй хүчтэй давж туулж буй санааг гаргахдаа их хүчтэй чанга авиа үсгийн нийлэмжээр ширүүн найруулгыг хэрэглэжээ.</p>	<p>Монгол хэлний өгүүлбэр судлал УБ., 2005 он</p> <p>Ж.Бат-Ирээдүй Монгол хэлний хэл зүйн дагавар нөхцөл, баймж үгийн сан УБ., 2009 он</p> <p>Ю.Мөнх-Амгалан Орчин цагийн монгол хэлний баймжийн ай УБ., 1998 он</p> <p>Пүрэв-Очир. Б “Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ” УБ., 2009</p>
--	--	--

Мэлтэлзсэн сүү шиг сарны туяанд
Гялталзсан шүүдэр сувдан өнгөтэй
Сугсалзан найгах өвсний толгойд
Сувдалсан шүүдэр намрын сүртэй
Түрэлхэн дайрах үдшийн бүрийг
Түгээмэл гийсэн саран цогтой (Ж.Бадраа Намрын шөнө)
Энэ шүлэгт ихэвчлэн “С,Ш” зэрэг исгэргэ гийгүүлэгчийг олноор оруулж шүлгийн мөр шад бүрт өтгөрүүлэн, чингэснээрээ сэрүүн сэнстэй намар цагийн хүйтэн жихүүний амьсгаа, чингэсэн атлаа тунгалаг цэмцгэр өнгийг үйл хөдлөлийн амьд эрчим дунд нь их нарийн уртай гаргасан юм. Ингэж авиа эгшгийн зохирлоор өтгөрүүлж, шингэрүүлж, шингэрүүлснээс өтгөрүүлж дууны яруу сайхан чанарыг төгс төгөлдөг бүтээж байсан уламжлал Монгол, дорно дахины уран зохиолын болон утга зохиолын онолын зүйлд арвин бий. (Л.Хүрэлбаатар Дуун утгын яруу зохист)

Үг, бүтээвэр, холбоо үг, нөхцөлийн найруулгын зэргийн утгыг жишээгээр тодруулан тайлбарлах

- Эхээс найруулгын зэрэг ялгамжийг илэрхийлсэн үг, өгүүлбэр, бүтээврийг ялган бүлэглэх
- Найруулгын зэргийг эхийн хам сэдвээс жишээгээр тодруулан тайлбарлах
- Найруулгын зэргийг баймж утгатай холбон тайлбарлах

Багшийн анхааралд:

Найруулгын зэргийг дээд (хүндэтгэлийн, эрхэмсэг), дундаж (ерийн), доод (доромж найруулга) гэж 3 ангилна.

Найруулгын дээд өнгө аястай үг хэллэгт бичиг зохиолын хэлний дээд хэм хэмжээнд тохирох үг багтдаг. Доод өнгө аястай үг хэллэгт этгээд, завхай, бүдүүлэг үг зэрэг бичиг зохиолын хэлний боловсронгуй найруулгад үл тохирох үг ордог. Найруулгын дээд өнгө аястай үг хэллэгт хуучирсан үг, шинэ үг, яруу найргийн үг, гадаад үгийг оруулан үздэг боловч эдгээр нь доод өнгө аястай найруулгын дотор ч байж болдог. Гэхдээ гол ерөнхий шинжээрээ ном судрын боловсронгуй найруулгад байх учраас дээд өнгө аястай үгэнд багтаан үздэг. Тухайн найруулгад орж байгаа үг нь үгийн сангийн аль давхаргад багтаж байгаатай үгийн өнгө ялгараа нь холбоотой байдаг.

Үүнээс үзвэл, дээд буюу бичгийн найруулга нь үйл ба хэрэг явдлыг бүрэн төгс, ихэд дэлгэрэнгүй өгүүлдэг бол ярианы ба доод найруулга нь үйл ба хэрэг явдлыг бүрэн бус, ихэд хураангуй өгүүлдэг байна. Доод найруулга нь бодит орчинтой нөхцөлдөж, аль болох бага зүйлд их санааг агуулан хураасан байдаг бол дээд найруулга нь бодит орчноос ангижирсан байх тул тухайн тэр


бүхнийг өргөн цар хүрээнд тод томруун дүрслэн үзүүлдэг учиртай. Дээд ба доод найруулга нь өнгө аясаараа дунд ба хар ярианы найруулгаас ялгарна.

Жишээ нь: Нүүдэлчин олдсон юмаа барин хамгаалж эхлэв.
Эхнэр хүүхэд хашхиран уйлж зуданд цадсан тарган ноход хуцалдан, цохиулсан хүмүүсийн ёолох дуутай нийлж, зүрх зүссэн авиа үүсэв. Гэвч улайрсан хүмүүс хашхиралдан бие биенээ хайр найргүй цохиж байв. /Ч.Л/ Зүрх зүссэн /зэвүүцэм аймаар/ гэсэн адилтгалаар бүтсэн хэлц холбоо үгийг эс тооцвол

	<p>энэ нь болсон хэрэг явдлыг ерийн өгүүлсэн дундаж найруулга болно.</p> <p>“Хасаг тэрэгний хяхнах тутам Лувсангийн сэтгэл уйтгарлаж хүрэн шарын хашигнах бүр түүний уур хүрнэ” /Д.Н/ гэвэл өгүүлбэрийг хэлбэрийн нэг бүтцэт дөрвөн өгүүлбэрийг жигдлэн тэгшилж, ойролцоо санаа бүхий өгүүлбэрийг салаавчлан холбосон тул дээд ба дундаж найруулгыг хосолжээ. “Тэрэг хяхнах, шар хашигнах, сэтгэл уйтгарлах, уур хүрэх” зэрэг нь найруулгын өнгө аясгүй учраас дундаж найруулга болно. Гагцхүү өгүүлбэрүүдийг утга санаагаар нь тэгшилсэнд дээд найруулгын шинж бүрджээ.</p> <p>Чи өлгөөд бай, би хазаарлаж авъя гэж хэлэв. /Ч.Л/ гэхэд “өлгө” гэсэн үг нь уургаар морины толгойг уургалахыг хэлж буй нь доод найруулгад хамаарна.</p> <p>“Гичий минь дуугүй бай, төрхөмд чинь залж орхино шүү” /Ч.Л/ гэхэд эхнэрээ эм нохойтой адилтгасан боловч энэ нь эх хүнийг ихэд доромжилсон хар ярианы бүдүүлэг үг болох учир доод найруулгад хамаарна.</p> <p>Чиний дэлгэрсэн лянхуа мэт нүүрийн дэлгэр саран ба чухам дэлгэрсэн удвал мэт мэлмий төгөлдөр болоод... Хөхөмдөг өнгө бие нь хөх удвал мэт. Зүүн мутартаа рашаан мэт бадар аяга барьж ... (“Монгол данжуур” магтаалын чуулган, УБ, 2011) ... Харах нүдний хар цагаан нь хослоод, хотын залуу хүний дээр эелдгээр хөдлөх тутамд миний нүд эрхгүй дагалдан давхина. (Д.Нацагдорж) Энэ муу нүд чинь хүйтэнд хөрдөггүй бүлтгэр, халуунд халдаггүй бүлтгэр шүү дээ.</p>	
--	--	--

12.2. БИЧИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>12.2а. Баримт нотолгоонд үндэслэн, учир шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг гаргаж тайлбарласан эсээ бичих</p>	<p>Баримт нотолгоонд үндэслэн, үзэл бодлоо илэрхийлж эсээ бичих Монгол хэлний заавал судлах цагийн 10 дугаар ангид “Тайлбарлан бичих”, 11 дүгээр ангид “Эргэцүүлэн бичих”, 12 дугаар “Ятган итгүүлж бичих” суралцахуйн зорилт байгаа бөгөөд сонгон судлахын энэ суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг тэндээс судлах боломжтой тул энд эсээ бичих гэсэн ерөнхий байдлаар зарим санааг тодруулан зөвлөмжлөв.</p> <p>Сэдвээ тодорхой сонгох: Байгаль, нийгмийн тудгамдсан асуудлаас сэдэв сонгох</p> <ul style="list-style-type: none"> • Тулгамдсан асуудлаар бичихийн тулд тухайн асуудлаа илүү тодорхой болгох • Сонгосон ерөнхий сэдвээ тодорхой сэдэв болгох 	<p>Ц.Өнөрбаян, Ж.Батбаатар “Эсээ бичихүйн үндэс” УБ.,2006</p>

<p>12.26. Тодорхой асуудлыг сэтгэгдэл, үзэл бодолтойгоо холбон олон талаас нь тунгааж, эргэцүүлсэн эсээ бичих</p> <p>12.2в. Баталгаа нотолгоонд үндэслэн, байр сууриа илэрхийлж, ятгасан эсээ бичих</p>	<p>“Орчны бохирдол” гэсэн ерөнхий сэдэв– усны бохирдол, хог хаягдал, бохир ус, хөрсний бохирдол гэх мэт олон дэд сэдвүүдэд хуваагдана. Иймээс “Хөрсний бохирдол” гэсэн сэдвийг сонгож авч болох юм. Бүр тодорхой болгохын тулд сэдвээ “Гэр хорооллын хөрсний бохирдол” гэж сонгох жишээтэй. Сэдвээ хэчнээн анхааралтай сонгоно бичих зүйл илүү тодорхой, ойлгомжтой, үр дүнтэй болно.</p> <div style="text-align: center;">  </div> <p>Ерөнхий Тодорхой Бүр тодорхой</p> <p>Сонгосон сэдвийн талаар байр сууриа илэрхийлэх буюу түлхүүр өгүүлбэрээ сонгох</p> <p>Түлхүүр өгүүлбэр нь энгийн нэгэн сэдэв биш, харин уг сэдэв асуудлын талаар зохиогч юу хэлэхийг хүсэж байгааг илтгэсэн гол санааны хураангуй илэрхийлэл юм. Энэ нь эсээ бичих явцад хөтөч болж, бичсэнээ бүхэлд нь хянахад тусална. Өөрөөр хэлбэл хөтөч санаандаа захирагдаж, түүний дагуу бичнэ гэсэн үг. Хөтөч санааг хэр сайн тодорхойлно, тэр хэрээр бичихэд амар болно. Хөтөч санаа тодорхой бус бол юм юм уруу орж, чухам юу хэлэх гээд байгаа нь уншигчид ойлгомжгүй болно.</p> <p>Түлхүүр өгүүлбэрийг бичихдээ дараах түгээмэл алдаанаас зайлсхийх</p> <ul style="list-style-type: none"> •Ерөнхийлөн тунхаглах •Хэт өргөн хүрээтэй ерөнхий баримт дурдах •Хэт явцуу, энгийн болох •Олон санаа агуулах <p>Түлхүүр өгүүлбэрийг олохын тулд тухайн сэдвээр өргөн хүрээнд уншиж судална. Унших явцад сэдвийн талаар “БИ ЮУ ХЭЛЭХ ВЭ? гэсэн өөрийн санаагаа тэмдэглэж явна. Тэмдэглэлээс байр сууриа илэрхийлж чадахуйц санааг сонгоно. Энэ нь эсээний түлхүүр өгүүлбэр болно. Түлхүүр өгүүлбэр эсээний гол санааг 1-2 өгүүлбэрээр илэрхийлэхээс гадна сэдвийн талаарх бичигчийн байр суурийг илэрхийлнэ.</p> <p>Сурагчдаар тухайн асуудлаар баримталж буй байр суурийг бичүүлнэ. Хос хосоороо бие биедээ бичсэн зүйлээ харилцан уншиж өгч, сэдвийн талаар өөрийн байр сууриа илэрхийлж чадсан эсэх, санаагаа хэр шинэлэг өвөрмөц, үнэ цэнтэй, эерэг байгааг ярилцана.</p> <p>Бичих санаагаа олж авах Тархины шуурга буюу оюуны довтолгоо</p> <p>Сэдвээ тодорхой сонгосны дараа бичихийн өмнөх алхам нь “санаа олж авах” – ын тулд “тархины шуурга” хийнэ. Энэ үйл ажиллагааны дараа илүү хурдан бичиж эхэлнэ.</p>	<p>Д.Баттогтох “Эсээ бичих эрдэм” УБ.,2016</p> <p>П.Батхуяг “Эсрэг хурд буюу эсээний тухай эсээ” УБ.,2017</p> <p>М.Монтень “Сонгомол эсээнүүд” УБ., 2010</p> <p>С.Батсүх, Д.Отгонсүрэн “Эсээ бичвэр ба илтгэх шалгалт” УБ.,2005</p> <p>Д.Баттогтох “Зуун найман эсээ” УБ., 2018</p> <p>Н.Батбаяр “Эсээний мөн чанар” УБ., 2018</p>
---	--	--

Сонирхолтой байр суурь баримтлан, оюуны довтолгоо хийж, дэмжлэг болох санааг цуглуулна гэдэг нь бүтээлчээр сэтгэхүй юм. Эсээ бичихийн тулд өгөгдсөн сэдвийг сонссон мөчөөс дотоод ухамсарт ямар нэг мэдрэмжүүд төрдөг бөгөөд улмаар тархинд санаа болон буудаг. Тэрхүү ухамсаргүй мэдрэмжийг аль болох дэврээж, үнэтэй, олон санаа болгон хувиргах нь чухал юм.

“Тархины шуурга”-ны нэг арга нь жагсаалт гаргах юм.

Жагсаалт гаргах:

Тухайн сэдвийн талаар санаандаа орж ирсэн үг, хэллэгүүдийн жагсаалт гаргана. Гол зорилго бол богино аль болох богино хугацаанд олон санааг олж, сэдэвтээ анхаарлаа төвлөрүүлэх явдал юм.

1.Цаасныхаа хамгийн дээд талд ерөнхий сэдвээ бичих

2.Дараа нь тухайн сэдвийн талаар санаанд орж ирсэн үг, хэллэгүүдийн жагсаалт гаргах. Бичихээсээ өмнө эдгээр санаагаа засварлах, шүүн тунгаах шаардлагагүй тул бодлоо бүү зогсоо, Удаан бодох тутам улам олон санаа орж ирнэ. Гэхдээ ерөнхий сэдвээ дагахыг хичээх хэрэгтэй.

3.Үг, хэллэг, өгүүлбэр ашиглах. Дүрэм болон үсгийн алдаанд санаа зовох хэрэггүй. Гол зорилго бол төрсөн санаанууд нь сэдэвт хамааралтай, сонирхолтой эсвэл чухал гэдэгт санаа зоволгүйгээр аль болох хурдан цаасан дээр буулгаж бичих явдал юм.

4.Ижил төстэй санаануудаа нэгтгэн багцлаад жагсаалтаа дахин бичих, давхардсан болон сэдэвт тохирохгүй санаануудыг хасах

Сэдвийн хүрээнд баримт хэрэглэгдэхүүн сонгох:

Судалгааны үр дүнд баримт бүрдэнэ. Эсээ бичигч нь агуулга мөн чанарыг илэрхийлэхүйц хамгийн сонирхолтой, өгөөжтэй, ач холбогдол бүхий баримтыг өндөр мэдрэмжээр сонгох хэрэгтэй. Үүний тулд янз бүрийн эх сурвалжтай ажиллан, баримт мэдээлэл цуглуулах, цуглуулснаа нарийвчлан судлах, эсээнийхээ сэдэв агуулгад нийцүүлэн шинжилж сонголт хийнэ. Үүнд бүтээлчээр, үр дүнтэй унших чадвар илүүтэй шаардагдана. Энэ нь хурдан унших биш бөгөөд уншаад ойлгох, хэрэгтэй зүйлсээ ангилан тогтоох, өөрийн зорилгод хандуулах зэрэг нь хамаарна.

Баримт нь: 1.Сонирхолтой байх 2. Гол санааг тайлбарлахад зориулагдсан байхад анхаарна. Эсээний гол болон дэд санаануудыг дэмжин өргөтгөх баримт мэдээллийг зохион байгуулах хоёр түгээмэл арга байдаг.

1.Цаг хугацааны дараалал баримтлах 2. Ач холбогдлын дараалал. Өөрөөр хэлбэл, хамгийн гол сонирхолтой чухал баримтаа хаана яаж байрлуулах вэ? гэсэн санаа юм. Баримт бол баталгаа нотолгоо, нөлөөлөл. Гайхам баримт


жишээ бол эсээний амин сүнс. Баримт мэдээллээс ангид зохиомж нь уншигчдад нөлөөлөх боломжгүй юм.

Баримтад дүн шинжилгээ хийх: Шууд ба шууд бус ажиглалтын баримтын аль нь вэ?, баримт уу? үзэл бодол уу?, Хэр үр дүн, ач холбогдолтой чухал баримт байна вэ?, Сэдэвтэй холбоотой байна уу?, Судалгаа шинжилгээний баримт, статистик тоон мэдээлэл, яриа, эшлэл, ном зохиолоос авсан жишээ гэх мэт ямар ямар төрлийн баримт байна вэ?, Баримт эх сурвалжтай юу? Хамгийн гол нь баримт нь үнэн үү? гэдгийг тогтоох гэх мэт...

Баримтаа үр дүн, ач холбогдлоор нь ангилж, эмхлэн цэгцлэх:

Жишээ нь: 3 цогцолбортой эсээ бичнэ гэж бодвол:

- Баримтуудаа агуулгаар нь 3 хэсэгт хуваагаад, нэр өгөх
- Хуудасны голд сэдвээ бичих
- Түүнийг тойруулан хэсгүүдийн нэрийг бичиж, байрлуулах
- Дараа нь уг хэсгүүдэд баримтаа харгалзуулан, бүлэглэх
- Хэсэг доторх баримтаа ямар дарааллаар байрлуулахаа шийдэх



Эсээний эхлэл, төгсгөл бичих:

Уншигчийн анхаарал татахаар, ямар нэг өнгө аяс агуулсан байх (хошин, нөхөрсөг, шүүмжлэлт, бахадсан г.м)

Эхлэл бол эсээ болон түүний сэдвийн талаарх уншигчийн анхны сэтгэгдэл, төсөөлөл юм. Иймд уншигчийн анхаарал, сонирхлыг татахаар эхлэх хэрэгтэй.

Эсээг хэрхэн эхэлж болох тухайд: Түлхүүр өгүүлбэрийнхээ санааг дэлгэрүүлэх баримтаар, бичиж байгаа зүйлийнхээ эсрэг санаа юм уу нөхцөлийг сонгон авах, сэдвийнхээ чухал болохыг уншигчид тайлбарлах, ямар нэгэн хэрэг явдал, товч түүх ашиглах, асуултаар эхлэх, эшлэлээр эхлэх, харин дүгнэлтээр, асуултаар, санал ба таамаглал дэвшүүлж төгсгөх зэрэг арга байдаг. Хамгийн сонирхолтой төгсгөл нь үргэлжлэлтэй мэт санагдах төгсгөл бөгөөд энэ нь асуултаар буюу асуулт үлдээх төгсгөл юм. Асуудал үргэлжилнэ. Үргэлжлэхдээ ямар нэг хэлбэрээр, өөр өнцгөөр үргэлжилнэ. Уншигч ургуулан бодож өөр өөрийнхөөрөө бодож төгсгөлд хүргэдэг. Энэ төгсгөл бол хамгийн түгээмэл хэлбэр юм.

Цогцолбор бичих: Цогцолбор нь 3 хэсгээс бүрддэг.

- 1.Толгой өгүүлбэр
- 2.Дэмжих өгүүлбэр
- 3.Дүгнэлт өгүүлбэр

Дүгнэлт өгүүлбэр бичих

1. Эхний цогцолборын гол санааг илэрхийлсэн толгой өгүүлбэр бичих
 2. Гол санааг дэмжсэн баримт, жишээ бичих
 3. **Цогцолборын дүгнэлт өгүүлбэр бичих**
-
1. Удаах цогцолборын гол санааг илэрхийлсэн өгүүлбэр бичих
 2. Гол санааг дэмжсэн баримт, жишээ бичих
 3. **Цогцолборын дүгнэлт өгүүлбэр бичих**
 4. **Цогцолбор тус бүрийн дүгнэлт өгүүлбэрт үндэслэн, эхийн дүгнэлт бичих**

- I. **Эсээний бүтэц:** Эсээ нь бичих зүйлийнхээ гол санааг бие, төгсгөл гэсэн гурван хэсгээс бүрдэх ба дунджа цогцолбортой байдаг байна. Мэргэжлийн эсээг бүтэц боломжгүй гэж үздэг бол, харин сургалтын эсээг тодорхой санал болгодог ба эсээний хамгийн түгээмэл бүтэц нь

- Ерөнхий мэдээлэл
- Гол санаа

II. ГОЛ ЦОГЦОЛБОР

A. Түлхүүр өгүүлбэр

1. Дэмжлэг
2. Дэмжлэг
3. Дэмжлэг

/ Дүгнэлт өгүүлбэр/

B. Түлхүүр өгүүлбэр

1. Дэмжлэг
2. Дэмжлэг
3. Дэмжлэг

/ Дүгнэлт өгүүлбэр/

V. Түлхүүр өгүүлбэр

1. Дэмжлэг
2. Дэмжлэг
3. Дэмжлэг

/ Дүгнэлт өгүүлбэр/

III. ДҮГНЭЛТ

Гол санааг дахин бичих буюу дүгнэж бичих, сүүлчийн санал

Толгой өгүүлбэр: Цогцолборын гол санааг илтгэнэ. Гол санаагаа олох явдал бичиж байгаа хүнд хэчнээн чухал байдаг вэ, толгой өгүүлбэр бол уншигчдад төчнөөн чухал байдаг юм. Энэ нь гол санаатайгаа ижил утгатай, өдөөх сонирхол төрлүүлэхүйц байх ёстой. Хэрвээ толгой өгүүлбэр

нь сонирхолгүй байвал баталгаа нотолгооны хэсэг хэчнээн сайхан байгаад ч нэмэргүй байдаг. Толгой өгүүлбэр нь:

- Цогцолборын гол санааг мэдэгдэнэ.
- Ихэвчлэн эхний 1-2 өгүүлбэр байна.
- Онцлон үзсэн, хураангуй гол санааг илтгэнэ.
- Хуурай биш, амьд сонирхолтой байна.

Өвөрмөц шинэлэг санаатай байх нь хамгийн чухал үзүүлэлт юм. Эсээнд “өвөрмөц, содон сонин, шинэ, даацтай” санаа гаргаж бичих нь чухал. Зохиолч До.Цэнджав энэ талаар “Маш өвөрмөцөөр сэтгэж, бүр байшгүйгээр сэтгэж бич. “Юмыг гурван талаас нь харахад гурван өөр харагддаг” гэж М.Ганди хэлсэн байдаг. Тэр өөр өнцгийг харж бич. Манайхан нэг талаас хардаг. Цасыг яагаад цагаан гэж... Д.Пүрэвдорж гуай “Хар цас” гэсэн. “За-гийн эсрэг үгүй, үгүй-гийн эсрэг за” дээр зогсох. Гэхдээ түүнийгээ нотол. Хүний сэтгэлд шинэ сонин төрөгдөл үүстэл, нээрэн ингэж сэтгэж болох юм байна шүү гэж зөвшөөртөл, итгэтэл, үнэмштэл бич. Юмны мөн чанар руу, гүн рүү нь ор. Эрэл хайгуул хий. Оюун санааныхаа гүн тийш, хязгааргүй тийш эрэлхийлж бич” ... гэжээ.

Ноороглох буюу чөлөөт бичлэг хийх

Боловсруулсан төлөвлөгөөний дагуу эхний санаагаа ноороглон бичих (Санаагаа холбох)

Зааврын дагуу бичээрэй.

- Цаасныхаа дээд талд сэдвээ бичнэ.
- Тухайн эхээр гаргах гол санаагаа 1-2 өгүүлбэрээр илэрхийлж бичээд, доогуур нь зурна. Ингэснээрээ эхийнхээ гол санааг үргэлж санана.
- Цаасныхаа мөрийн хооронд 1-2 мөр бичих зай, цаасныхаа 2 талд мөн зай үлдээнэ. Бичсэнээ сайжруулахын тулд эдгээр зайнд шаардлагатай баримт жишээг дараа нь нэмж бичнэ.
- Төлөвлөгөөний дагуу эхний нооргоо бичээрэй. Сэдэвтэй холбоотой баримт, жишээ, үзэл бодлоо багтааж, тасралтгүй бичихийг хичээ. Төлөвлөгөөнд байхгүй санааг нэмэх хэрэггүй.
- Эхний ноорог төгс байх шаардлагагүй тул цэг тэмдэг, үг үсгийн алдаанд санаа зоволгүй төлөвлөгөөний дагуу аль болох их бичих хэрэгтэй.
- Бичих явцдаа санаагаа бүрэн гаргаж чадахгүй бол зай орхиод дараа нь нөхөж бичиж болно.
- Бичих явцад өөр шинэ, чухал санаа төрвөл мартагчийн тулд даруй цаасныхаа хажуу талын зайнд тухайн хэсгийн харалдаа тэмдэглэж авна.

	<p>Агуулга, бүтцээ хянах</p> <p>Эхний нооргоо бичсэн дараа түүнийг сайжруулах үе шат байна. Бичсэнээ дахин хянахдаа түүнийг сайжруулахын тулд өөрчилж болно. Эхийн нэгж, уялдаа холбоо, логик дарааллыг багтаан агуулга болон бүтцийг дахин хянана. Өөрийн бодлоо илүү тодорхой, үр дүнтэй, сонирхолтой болгохын тулд эхээ дахин эмхлэх, нэмэх, хасах зэргээр өөрчилж болно. Эхний удаа хянахдаа өгүүлбэрийн бүтэц, зөв бичгийн дүрэм болон цэг тэмдгийн алдааг засах гэж оролдох хэрэггүй, эдгээр нь дараа хяналтын уншилтын явцад хийэ. Эхний хяналтаар эхийн агуулга болон бүтцэд голлон анхаарлаа хандуулна.</p> <ul style="list-style-type: none"> • Эсээгээ ерөнхий байдлаар тоймлон уншина. • Эхийн ерөнхий санаанд голлон анхаарч, цаасны хажуу зайнд сайжруулах шаардлагатай хэсгүүдийг дахин бичих • Өөрийн онцлон тэмдэглэсэн зорилгодоо хүрсэн эсэхийг шалгах • Утгын ерөнхий дэс дараалал, уялдаа холбоог хянах. • Уншигч үзэл бодлыг чинь хүлээн зөвшөөрч, бичсэн зүйлийг хялбар ойлгохоо байх • Түлхүүр өгүүлбэртэй эсэхийг хянах • Түлхүүр өгүүлбэрийн санааг дэмжихгүй байгаа өгүүлбэрүүдийг хасах • Цогцолбор бүр сэдвийн гол санааг уншигчид ойлгохуйц мэдээлэл өгөх • Хэрвээ эхийн гол санааг дэмжих хангалттай мэдээлэлгүй бол хажуу зайнд “санаа нэмэх, жишээ оруулах” г.м тэмдэглэл хийнэ. • Эцэст нь дүгнэсэн өгүүлбэр байгаа эсэхийг хянах 	
<p>12.2г. Эхэд найруулгын зэрэг, баймж утгыг илэрхийлж бичих</p>	<p>Эхэд баймж утгыг илэрхийлж бичих</p> <ul style="list-style-type: none"> • Эхийн баймж нэгжийг солин найруулж, найруулгад илрэх, өнгө аяс үнэлэмж ялгарааг тайлбарлах • Цогцолборыг баймж нэгжээр дэлгэрүүлэх • Итгэсэн, эргэлзсэн, дурлаж шимтсэн, хүсэж гуйсан, захирч тушаасан, сануулсан, ерөөсөн ... гэх мэт хандлагыг илэрхийлсэн баймж өгүүлбэр зохиох • Бүтэц ба бүтэц бус өгүүлбэрийг утга төгөлдөр хослуулан найруулах • Бичлэгийн төрөл зүйл, найруулгын зэрэг, өнгө аяс, өгүүлэгчийн үнэлэмж зэрэгт нийцүүлэн баймж үг, өгүүлбэрийг сонгох <p>Багшийн анхааралд: Баймж утга гэдэг нь өгүүлэгчээс тухайн зүйлд хандах хандлагыг хэлдэг. Тиймээс баймж утгат хэлний нэгжүүдийг хэрэглэж сурахын тулд эхлээд өгүүлбэр зохиох, өгүүлбэрт нөхөх, солин найруулах зэрэг энгийн даалгавруудыг гүйцэтгэнэ. Үүний дараа эх зохион бичихдээ хэрэглэж</p>	<p>Ж.Бат-Ирээдүй Монгол хэлний хэл зүйн дагавар нөхцөл, баймж үгийн сан Уб., 2009 он</p> <p>Ю.Мөнх-Амгалан Орчин цагийн монгол хэлний баймжийн ай Уб., 1998 он</p>

	<p>сурахад анхаарна. Эх зохион бичих сэдэв сонгосныхоо дараа уг асуудалд бичигч өөрөө ямар хандлагаар бичихээ төлөвлөнө. Тэгээд сэдэв, санаа, өөрийн хандлагадаа тохируулан хэлний нэгжээ сонгоно. Баймж утгат хэлний нэгжийг хэрэглэснээрээ бичигчийн уг зүйлд хэрхэн хандаж буй хандлага уншигчдад тодорхой болдог. Өөрөөр хэлбэл бичигч өөрийнхөө “би”-г бусдад таниулах нэг арга юм.</p> <p>Жишээ нь: Цогцолборын утга санааг аа яа яа, даа, мөртлөө, ч, ч гэсэн, л юм, юм шиг, өө чааваас....юм, биз, ч юм ч үгүй байж, маш их, хөөрхий..... шүү, үнэнийг хэлэхэд, дам сонсвол гэнэ ээ, ний нуугүй хэлэхэд шүү, хараажаар люм байна гэх мэт баймж үг, өгүүлбэр нэмж, найруулгад илрэх, өнгө аяс үнэлэмж ялгарааг тайлбарлах гэх мэтээр дасгал ажиллаж болно.</p> <p>Эхэд найруулгын зэрэг илэрхийлж бичих</p> <ul style="list-style-type: none"> • Цогцолборын найруулгын зэргийг хувирган бичих, ямар зэрэгт хувиргаснаа батлан тайлбарлах • Найруулгын зэрэг ялгамжийг илэрхийлсэн өгүүлбэр, үг, бүтээврийг сонгон найруулах 	
<p>12.2д. Эхийн бүтэц, агуулгыг өөрчлөн найруулж бичих</p>	<p>Эхийн бүтэц, агуулгыг өөрчлөн найруулж бичих Тус суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмж 12 дугаар ангийн багшийн номд тодорхой жишээгээр маш дэлгэрэнгүй тайлбарласан тул тухайн зөвлөмжөөс анхааралтай судална уу. Цогцолбор, эхийн цөм санаанд тулгуурлан найруулгын хэв маягийг өөрчилж, утга, хэлбэрийн зохистой нийцэл бүхий хувилбар бий болгох нь сэтгэн бодох, хувирган өөрчлөх, зохион бүтээх, найруулан бичих зэрэг олон үйлийн уулзварт хийж буй дээд эрэмбийн чадвар шаардсан үйл ажиллагаа болох тул үүнийг аль болох энгийн ойлгомжтой хялбар эхийн жишээнээс эхэлж, алхам дарааллаар ахиулбал зохилтой. (А.Цог-Очир нар “Багшийн ном” 12 дугаар анги)</p>	<p>А.Цог-Очир нар Монгол хэл багшийн ном 12 Уб., 2018 он</p>

12.3.СОНСОХ- ЯРИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	хэрэглэгдэхүүн
<p>12.2а. Дэвшүүлсэн асуудлын талаарх үзэл баримтлалыг тоймлож бүлэглэх, шинэ баримт дүгнэлтийг танилцуулах, зөрөлдөөнтэй саналыг ангилах,</p>	<p>Дэвшүүлсэн асуудлын талаарх үзэл баримтлалыг тоймлож бүлэглэх, шинэ баримт дүгнэлтийг танилцуулах, зөрөлдөөнтэй саналыг ангилах, чухал асуудлыг онцлон тэмдэглэх, дүгнэлт хийх Дэвшүүлсэн асуудлын талаарх үзэл баримтлалыг тоймлож бүлэглэх,</p> <ul style="list-style-type: none"> • Дэвшүүлсэн асуудалтай танилцах • Дэвшүүлсэн асуудлын талаар судалсан судалгаа, эрдэмтдийн санал бодол, үзэл баримтлалыг уншиж судлах 	<p>Ричардс.Ж, Рикет.Г “Мэтгэлцээн” УБ., 2001</p>

<p>чухал асуудлыг онцлон тэмдэглэх, дүгнэлт хийх</p>	<ul style="list-style-type: none"> • Дэвшүүлсэн асуудлын талаарх үзэл баримтлалыг тоймлож бүлэглэх • Асуудлын талаарх шинэ баримт мэдээлэл, үзэл баримтлалыг тодруулах • Дэвшүүлсэн асуудлын талаарх зөрөлдөөнтэй саналыг ангилах • Дэвшүүлсэн асуудлын талаарх шинэ баримт дүгнэлтийг танилцуулах • Баримт нотолгоонд үндэслэн асуудлын шалтгаан үр дагаврыг олж тогтоох • Чухал асуудлыг онцлон тэмдэглэх, асуудлын мөн чанарыг дүгнэх 	
<p>12.26. Сонссон, уншсан мэдээллийг эргэцүүлэх, дүн шинжилгээ хийж, үзэл бодлоо илэрхийлэх</p>	<p>Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үзэл бодлоо илэрхийлэх</p> <p>Мэдээллийн эх сурвалж маш их болсон өнөө үед бүх мэдээлэлд итгэх боломжгүй. Тиймээс мэдээллийн үнэн бодитыг нягтлах, дүн шинжилгээ хийх чадварт суралцах шаардлага тулгарч байна.</p> <p>Мэдээлэлд дүн шинжилгээ хийхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээлэл бодитой юу? албан ёсны эх сурвалж, баримт нотолгоотой юу? мэдээлэлд дурдагдсан эх сурвалж, нэр баримт зураг, дүрсээр хайлт хийж магадлах • Мэдээний хэл найруулга, бичлэг ямар байна вэ? Сайн мэдээлэл үндэслэлтэй баримтаар эхэлдэг, цэгцтэй, дэгсдүүлсэн байдал, сэтгэл хөдлөл их байвал анхаарах • Энэ мэдээ мөн үү? эсвэл хэн нэгний үзэл бодол уу?, мэдээ ихэвчлэн болж буй үйл явдлыг тайлбарлаж, хувийн үзэл бодлыг илэрхийлэхээс зайлсхийдэг. Үзэл бодол бол шүүсэн дүгнэсэн өнгө аястай, бичиж буй хүн өөрийн өнцгөөс хэлсэн байдаг. • Мэдээг баримтаар баталгаажуулсан байна уу? Бичсэн хүн нь мэдээллээ статистик судалгаа, жишээ баримтаар баталгаажуулсныг хянах • Нэг талыг барьсан биш биз? Баримтууд тухайн үйл явцыг цогцоор нь ойлгоход тусалж чадаж байна уу? Гол баримтуудыг орхиж, асуудлыг хязгаарлагдмал байдлаар харсан байна уу? Гол үйл явдлаас холдуулж хальсан байна уу? гэдгийг харах • Хэн нэгний эрх ашигт үйлчилсэн байна уу? Гарчгаас эхлээд хэн нэг хүний үзэл бодлыг дэмжсэн байна уу? гэдгийг анхаарах • Уншигчдыг хөгжөөх зорилготой байна уу? мэдлэг мэдээлэл өгсөн байна уу? зарим мэдээ хүмүүсийг хагаралдуулах, хүмүүсийн сонирхол хандлагыг тандах, бусдын нэр сүрийг гутаах зорилготой байдгийг санах • Мэдээллийн үр дүн юу? гэдгийг харах <p>Мэдээллийн бичиг үсэгт тайлагдсан байдал</p>	<p>Ричардс.Ж, Рикет.Г “Мэтгэлцээн” УБ., 2001</p>

	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл үнэн, худал эсэхийг тунгааж, шүүмжлэлт сэтгэлгээр уншиж байна уу?... • Юуг уншиж, юуг уншихгүй вэ?, юунд итгэх эсвэл итгэхгүй вэ? гэдгээ ухамсартайгаар шүүн тунгааж байна уу? • Сөрөг нөлөөллөөс хэрхэн сэргийлж болохыг мэддэг байх. <p>Багшийн анхааралд: Асар хурдтай хувьсан өөрчлөгдөх технологи хүүхдийн өмнө урд хожид байгаагүй их мэдээллийг дэлгэж байна. Уншигчид мэдээлэлд зөв, зохистой задлан шинжилгээ хийж, ялган таньж, аливаа мэдээллийг цааш нь түгээхээсээ өмнө бодож, нягталж шийдвэр гаргахыг сурагчдад заах, энэ хандлагыг төлөвшүүлэх хэрэгцээ тулаад байна. Мэдээллийн бичиг үсэгт тайлагдахгүй бол тоо томшгүй их хуурамч мэдээллийн урсгал хувь хүнээр зогсохгүй улс үндэстний аюулгүй байдалд ч заналхийлэл учруулах эрсдэлтэй аж.</p>	
--	---	--

12.4. ҮГИЙН САН, ХЭЛ ЗҮЙ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа		Хэрэглэгдэхүүн
<p>12.2а. Баймж бүтээвэр, үг, өгүүлбэрийг өгүүлбэрт найруулж, утгын хувирлыг тайлбарлах</p>	<p>Баймж бүтээвэр</p> <p>-үйл үгийн нөхцөл -маш, тун, хав, пид, нов, ув, юм, -аа, гэх мэт чимэх үгс -сан4, дээр вэ? бол, нь -хан4, -втар4, -дуу2</p>	<p>Баймж үг</p> <p>*үзэж магадгүй, очилгүй яахав, мэдэх учиртай, ёстой, адаглаад, ашгүй, явах бололтой, өөрийн мэдэлгүй, -аас зайлахгүй, нөхцөлгүй *тавласан, өрөвдсөн, хүссэн, цээрлэсэн, дургүйцсэн утгатай үг *хандсан үг</p>	<p>Ю.Мөнх-Амгалан Орчин цагийн монгол хэлний баймжийн ай УБ., 1998 он</p>
	<p>Баймж оруулбар үг</p> <p>-үнэн хэрэгтээ, мэдээжийн хэрэг, дам сонсвол, үнэнийг хэлбэл, чухамдаа, ний нуугүй хэлэхэд, хараажаар, олны хэлэлцэх нь, дашрамд нь, азаар, харамсалтай нь, магадгүй, ёоз нь, юм шиг бай-, гомдолтой нь</p>	<p>Баймж өгүүлбэр</p> <p>*мэдрэх өгүүлбэр: ёх ёх, пөөх, аа яа яа, түй, өө, паа *зөвших өгүүлбэр: за, үгүй, мөн, биш, байз, хаанаас даа, бүү мэд, ёстой доо, нээрээ *илэрхийлэх өгүүлбэр: хөөрхий, иш чааваас, уухайс даа, үхсэн хойноо, гялай, золиг, халаг *харилцах өгүүлбэр: өөв, еэ еэ бөө бөө, май, бүүвэй, уухай, ура, хөж</p>	<p>А.Цог-Очир</p>
	<p>Мэдээллийг цэгцэлж, тулгуур бичиглэл, бүдүүвчээр загварчлах</p>		<p>А.Цог-Очир</p>

<p>12.26. Мэдээллийг цэгцэлж, тулгуур бичиглэл, бүдүүвчээр загварчлах</p>	<ul style="list-style-type: none"> • Тулгуур бичиглэл, бүдүүвчийн мэдээллийг тайлбарлан бичих • Мэдээллийг анхааралтай уншиж судлах, ойлгох • Мэдээллийн адил төстэй талыг тогтоох • Мэдээллийн хэсгүүдийн хоорондох шалтгаан-үр , болзол-үр дагаврын харьцааг тогтоох • Мэдээллийг жиших, эсрэгцүүлэх • Эхэд мэдээллийн хэсгүүдийг хэрхэн холбосныг задлан шинжилж, утга санааны авцалдаа, харьцаа, учирзүйн дарааллыг тогтоох • Мэдээллийг бүлэглэх, төстэй шинжээр нь нэгтгэх <p>Багшийн анхааралд: А.Цог-Очир нарын 12 дугаар ангийн монгол хэлний багшийн номд тус суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй зөвлөмж байгаа болно. Өмнөх сургалтын цөм хөтөлбөрт “Хэлний тогтолцоот мэдлэгээ цэгцэлж, тулгуур бичиглэл, бүдүүвчээр загварчлах” гэж байсныг “Мэдээллийг цэгцэлж, тулгуур бичиглэл, бүдүүвчээр загварчлах” гэж өөрчилсөн. Энд юуг гэдэг нь өөрчлөгдсөнөөс, яаж гэдэг нь хэвээр тул мэдээллийг хэрхэн загварчлах талаар багшийн номоос анхааралтай судлах хэрэгтэй юм. Мэдээллийг боловсруулах нь монгол хэлний хичээлээр эзэмших үндсэн арга барил юм. “Мэдээллийг бүдүүвчлэх, загварчлах” нь мэдээлэл боловсуурлах өндөр түвшний чадвар бөгөөд энэ чадварыг олгохын тулд юуны өмнө загвар бүдүүвчээс мэдээллийг тайлан унших дадлага хийх, мэдээллийг хэрхэн бүдүүвчилж, загварчилсныг тайлбарлан ярилцана. Жишээ нь дараах бүдүүвчийг тайлан унших, мөн өөрсдөө мэдээллийг бүвүүвчлэх дадлага ажлыг гүйцэтгэнэ. М.Базаррагчаа нар “Монгол хэл” 10 Уб., 2006 он, 40 дүгээр тал</p>	<p>Монголхэл Багшийн ном Уб., 2018</p>
--	---	--

Төгс санаа бүхий хэрэг явдлын учир утга, түүний зогсонги, хөдлөнгө шинэжлийг утга соёлын үүднээс торхах хэлээрээ бүтээснийг эх гэнэ. Үүнийг шинэчлэн судалбал эх судлал болно.

ЭХ БОЛ ХЭЛЭН ДЭХ СЭТГЭЛИЙН ЕРТӨНЦ МОН.

